



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: АШУҮИС-ийн Био-Анагаахын Сургууль

Хөтөлбөрийн нэр: Био-анагаах ухаан

Индекс: D091401

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Уламбаяр

Гишүүд: Н.Наранбат, Г.Түвшинжаргал

Огноо: 2023-12-12

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУҮИС-ийн Био-Анагаахын Сургууль School of Biomedicine	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Био-Анагаах Ухаан Biomedicine	
Индекс	D091401	
Шинжээчид	Л.Уламбаяр- Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн захирал Ph.D Н.Наранбат-Гялс анагаах ухааны төвийн ТУЗ-ийн дарга Ph.D Г.Түвшинжаргал-Этүгэн их сургуулийн Био-анагаах ухааны багш Ph.D	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	12.12.2023	Сургуулийн орчинтой танилцах
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	13.12.2023	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
Багш нартай уулзах		
Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах		
Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Био-анагаахын сургууль нь нийгмийн хариуцлагын хүрээнд дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэн, өөрийн оронд био-анагаахын мэргэжилтэн бэлдэх зайлшгүй шаардлага, хэрэгцээг үндэслэн 2000 оноос өнөөг хүртэл Био-Анагаах судлаач мэргэжилтний хөтөлбөрийг хэрэгжүүлэн 19 удаагийн төгсөлтөөр 668 мэргэжилтнийг бэлтгэн гаргасан байна. Инноваци, өндөр технологи, шинэ мэдлэг бүтээх чиглэлд хурдацтай хөгжиж, анагаах ухаан, эрүүл мэндийн салбарт дэвшил авчирч буй нэг чухал салбар бол био-анагаах юм. Био-Анагаах ухааны салбарыг Монгол Улсад хөгжүүлэхэд Био-анагаах судлаач мэргэжилтнүүд голлох үүрэг гүйцэтгэдэг. Био-Анагаах судлаач мэргэжилтэн бэлтгэх 2+3 хөтөлбөр нь суурь боловсролын дамжаа (2 жил), мэргэжлийн суурь, мэргэшүүлэх (3 жил) зэрэг ерөнхий эрдэм, анагаахын суурь болон мэргэжлийн суурь хичээл заадаг 16 тэнхим, 16 профессор, 25 дэд профессор, 75 доктор бүхий нийт 146 багш ажилтантай 301 оюутантай сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтыг танхим болон цахим хэлбэрээр нийт 86 хичээлийг 72 анги, лекцийн 8 танхим, сургалт судалгааны 11 лаборатори, мультимедиа, био-анагаахын хүрээлэн зэргийг түшиглэн зохион байгуулдаг байна.

Хөтөлбөрийн зорилго, хэрэгцээ:

Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо: Орчин үеийн техник, технологи бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад ажиллах чадвартай, олон улсын түвшинд дүйцэхүйц судалгаа, сургалт, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвартай, “Био-Анагаах”-ын чиглэлийн бакалаврын боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Тус хөтөлбөр нь 2010, 2017 онд магадлан итгэмжлүүлж, 2023 онд 3 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэх гэж байна. Био-анагаах судлаач хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 368-р тогтоолд “Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт (2015-2021 он)”-ын “Хүний хөгжил, хүрээлэн буй орчин” тэргүүлэх чиглэлийн 2 дугаарт, засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэлд тус тус тусгагдсан байна.

Монгол Улсын хэмжээнд оношилгооны 400 орчим лаборатори ажиллаж байгаагаас нийслэл хотод 150 орчим улсын болон хувийн хэвшлийн лаборатори ажиллаж байна. Эдгээр лабораторийн нийт ажиллах хүчний ойролцоогоор 65 хүртэл хувь нь био-анагаах ухааны мэргэжилтэн байна. 2023 оны байдлаар нийт төгсөгчдийн 61% нь эрүүл мэндийн салбарт, 18% нь шинжлэх ухаан, боловсролын салбарт, 21% нь эм, биобэлдмэл, үйлдвэрлэл, суурь судалгааны чиглэлээр ажиллаж байгааг харахад хөрвөх чадвартай мэргэжил байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн: PLOs (Program Learning Outcomes)

- Төгсөгчийн эзэмших 7 чадамж

Хичээлийн хөтөлбөрийн хүрэх үр дүн CLOs (Course Learning Outcomes)

- 251 мэдлэг
- 195 чадвар
- 144 хандлага эзэмшинэ

Дараах зарчмыг баримталж байна.

Сургалтыг нотолгоонд тулгуурлан, мэдээллийн сүүлийн үеийн технологи ашиглаж, чанартай явуулах үндсэн аргыг мөрдлөг болгодог зарчимд тулгуурладаг.

Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт

№	Багц цагийн агуулга	Нийт багц (%)			
		A/174	2015	2016	2021
1	Ерөнхий суурь	30%-иас бага	46 (28%)	44 (27%)	40 (24.4%)
2	Мэргэжлийн суурь	25%-иас бага	37 (22.6%)	35 (21.3%)	28 (17%)
3	Мэргэшүүлэх	45%-иас их	81 (49.4%)	70 (42.7%)	82 (50%)
4	Дадлага			15 (9%)	14 (8.6%)
	Нийт	100	164.0	164.0	164.0

Хөтөлбөрийн онцлог:

Сургалтын нэгдмэл хөтөлбөр нь

- Асуудлыг мэдээлэх хэлбэрээс асуудлыг шийдвэрлэх хэлбэрт шилжсэн
- Сургалтыг эмнэл зүйн лабораторийн практикт ойртуулсан
- Дидактик сургалтаас оюутны бие даасан, өөрөө өөрийгөө удирдан сурах оюутан төвтэй сургалтад шилжсэн
- Олон хичээл, салбарын мэдээллийг нэгтгэж уялдуулсан
- Оюутанд насан туршид сурах арга барилыг эзэмшүүлдэг
- Оюутанд багаар ажиллах чадварыг хөгжүүлж тэднийг харилцааны соёлд сургах

Сургалтын хөтөлбөрийн ороомог хэлбэр, интеграчлал (R.H.Harden “Practical guide for medical teachers”, 1997)

- Ороомог хэлбэрийн хөтөлбөрийн загвараар оюутан онолын болон эмнэл зүйн шинжлэх ухаан, эмнэл зүйн болон харилцааны ур чадвар гэсэн үндсэн хоёр зорилгыг зэрэгцүүлэн 3 үе шатаар сургалтыг дамжин суралцдаг. Үүнд:
 - I. Эрүүл бүтэц, үйл ажиллагаа, зан үйл
 - II. Эмгэг бүтэц, үйл ажиллагаа, зан үйл
 - III. Лабораторийн мэргэжилтний мэргэшүүлэх сургалт

“АШУҮИС-ийн Сургалтын технологи чанарын хяналтын үлгэрчилсэн журам”-ыг мөрдөн мэргэжлийн хөтөлбөрийн арга зүйг сургалтын SPICES дараах загвараар хэрэгжүүлдэг. Үүнд:

- Student centered-оюутан төвтэй
- Problem based-асуудалд суурилсан
- Integrated-нэгдмэл
- Community oriented-нийгэмд чиглэсэн
- Elected-сонголттой
- Systematic-системтэй аргыг ашиглан хэрэгжүүлдэг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Био-анагаах судлаач мэргэжилтний эрүүл мэндийн салбар дахь хэрэгцээ, шаардлагыг гаргасан. Сүүлийн үед хиймэл оюун ухаан, биотехнологийн үсрэнгүй хөгжлийн энэ үед био-анагаах ухаан, биотехнологи, хиймэл оюун ухаан мэдээллийн технологийг эмчилгээ, оношилгоо урьдчилан сэргийлэлтэд эмчийн ур чадвар, эмнэлзүйн сэтгэлгээтэй хослуулан ашиглах, хөгжүүлэх, оновчтой шийдвэр гаргах зэрэг шинээр үүсч буй шаардлагыг хангахад нотолгоонд суурилсан анагаах ухааныг гол хөгжүүлэгч нь био-анагаах судлаач нар юм.
- Монгол Улсын хэмжээнд оношилгооны 400 орчим лаборатори ажиллаж байна. Эдгээр лабораторийн ажиллах хүчний 65 хүртэлх хувь нь био-анагаахын мэргэжилтэн ажиллаж байгаа нь энэхүү мэргэжил хэрэгцээ шаардлагатай байгааг харуулж байна.
- Онош зүйн лабораторт ажиллах боловсон хүчин хомс байна.
- Эм, биобэлдмэл үйлдвэрлэл, суурь судалгааны салбар дах хэрэгцээ, шаардлагыг судалсан.
- Эм, биобэлдмэл шинээр үйлдвэрлэхэд эмнэл зүйн судалгаа хийгдэж байж зах зээлд гаргах зөвшөөрөл авдаг. Энэхүү судалгааг мөн био-анагаахын мэргэжилтэн хийнэ.
- Боловсролын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг судалсан.
- Багш-судлаачаар ажиллах боломж өндөр байна. Тухайлбал мэргэжилтэн, нийт төгсөгчдөөс 2 дэд профессор, 17 доктор, 79 магистр, 1 тэргүүлэх зэргийн био-анагаах судлаач төрөн гарсан байгаа нь боловсролын салбарт хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
- Сургалтын хөтөлбөрийг гадаадын ижил төстэй 8 сургууль (University of York, University of Strathclyde, Glasgow, The university of Edinburgh, University of Southampton, European University Cyprus, University of Portsmouth, Bangor University), дотоодын 2 их сургууль (Этүгэн, МУИС)-тай харьцуулахад зайлшгүй судлах үндсэн хичээл, сонгон суралцах болон дадлагын хичээлийн тоо, багц цагаараа ижил төстэй байгааг судалж, сайжруулалт хийж, боломжийг эрэлхийсэн байна.
- Дээрх гадаадын их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулснаар лабораторийн амьтан судлал, хиймэл оюун ухаан, био-инженерчлэлийн үндэс, био-анагаахын өгөгдлийн шинжилгээ, эмнэлгийн анхны тусламж, гамшгаас хамгаалах менежемент, онош зүй зэрэг хичээлийг сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулсан байна.

Онцлог зүйл:

- Био-анагаах судлаачаар ажиллаж буй мэргэжилтний сэтгэл ханамж өндөр

Анхаарах асуудал:

- Гадаадын хөтөлбөрийн нэг кредитэд оногдох цаг ялгаатай байгааг цаашид хөтөлбөрийн харьцуулалт хийхэд анхаарч ажиллах
- Хөтөлбөрийн агуулгын харьцуулалт хийсэн боловч кредит цаг нилээд зөрүүтэй байгаа нь бэлтгэн гаргаж буй мэргэжилтэн олон улсын түвшинд дүйцэхүйц гэдэгтэй нийцэх эсэх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хэрэгцээ шаардлагыг тоон мэдээлэлд үндэслэн гаргах, цаашдын прогнозыг гаргах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн эрхэм зорилго “Шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль байна” гэсний дагуу нэгдмэл нэг зорилгын хүрээнд энэхүү салбарт ажиллах боловсон хүчин нь олон улсын түвшинд дүйцэхүйц судалгаа, сургалт, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ гэж хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон байгаа нь уялдаа хамаарал бүхий байна.
- Мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлсон.
- Мэргэжилтний хөрвөн ажиллах боломж, чиглэлийг тодорхойлсон. (Эрүүл мэндийн салбар, шинжлэх ухаан, боловсролын салбар, эм, биобэлдмэл үйлдвэрлэл, суурь судалгаа)
- Хөтөлбөрийн зорилгод хүрэх үр дүнд 4 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:
 1. Био-анагаахын чиглэлийн эрдэм шинжилгээний лабораториудын үйл ажиллагаатай уялдуулан судалгаа, шинжилгээ хийх сургалтын тогтолцоог бий болгох
 2. Эрдэм шинжилгээний нэгдсэн лаборатори байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ээлтэй орчин бүрдүүлэх
 3. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хөрвөх чадвартай Био-анагаах судлаач мэргэжилтэн бэлтгэх
 4. Хөгжингүй орнуудад хэрэгжиж буй сургалтын тэргүүний технологийг өөрийн орны нөхцөлд бүтээлчээр нэвтрүүлэх

Онцлог зүйл:

- Мэргэжилтний цогц чадамжийг боловсруулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэргэжлийн онцлогоос шалтгаалан оролцогч талуудын оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх. (Багш, оюутан, төгсөгч, ажил олгогч). Тэдний санал хүсэлт, зөвлөмжийг тусгаж ажиллах
- Цаашид хөтөлбөрийн орц, гарц, явцыг үнэлж, сайжруулалт хийж хэвших
- Хөтөлбөрийн PEO, PLO, CLO-ийн уялдаа хамаарал бүхий матрицыг боловсронгуй болгох
- Мэргэжилтний загварыг ажлын байрны тодорхойлолтоос ангид товч, ойлгомжтой байдлаар дүрслэн тодорхойлох

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг боловсруулахад БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын мэргэжлийн чиглэлд таигдах нийтлэг шаардлага”, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах -2024, ЭМСайдын 2012 оны 05 сарын 14 өдрийн 168 тоот тушаал Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар, зураглалыг 6 дугаар хавсралтаар, 2015 оны 1 сарын 2-ны өдрийн 501 дугаар тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварын нэгдүгээр хавсралтаар, Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй биоанагаахын мэргэжилтний ажлын байрны үлгэрчилсэн загвар тус тус батлагдсан байна.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, хоёрдугаар хавсралтаар Сургалтын технологи, чанарын хяналтын журам,
- Дээд боловсролын сургалтын байгууллагат тавигдах шаардлага зэргийг үндэслэн Монгол Улсад мөрдөгдөж буй эрхзүйн баримт бичгийн шаардлагад нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Био-Анагаах судлаач мэргэжилтэн бэлтгэх 2+3 сургалтын хөтөлбөрийг 2 удаа магадлан итгэмжүүлсэн.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг хөтөлбөрийн дэд хороо (2021 оны 05 сарын 14-ний хурал) болон ерөнхий хороо (2021 оны 06 сарын 17-ны хурал)-оор хэлэлцэн баталсан.

Онцлог зүйл:

- 2 удаа магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөртэй.
- Хөтөлбөрийн хороодын чиг үүрэг тодорхой, тогтмол ажилладаг.

Анхаарах асуудал:

- Суралцахуйн үр дүнгийн матриц (нэгдсэн)-ыг гаргах, тодорхой болгох

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт аргыг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх
- Хөтөлбөрт гарч болох үл тохирлуудыг гаргадаг байх, цаашид засаж залруулах ажлын төлөвлөгөө гаргах, сайжруулалт, ахиц дэвшлийг гаргадаг байх

Дүгнэлт:

Хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгцээ шаардлага, зорилго, баримт бичиг нь Дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалт, мэргэжлийн стандарт, стратеги, боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн сургалтын хөтөлбөрт тавигдах шалгуур шаардлага зэрэг хууль эрх зүйн актуудыг бүрэн хангасан.

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Орчин үеийн техник, технологи бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад ажиллах чадвартай, олон улсын түвшинд дүйцэхүйц судалгаа, сургалт, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвартай "Био-анагаах"-ын чиглэлийн бакалаврын боловсролтой мэргэжилтэн бэлтгэж байна.

- 2018-2023 онуудад суралцагчийг үнэлэх журам, сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам, багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, багшийн алтан дүрэм болон бусад хууль, журам, дүрэм, эрх зүйн актыг сургалтын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.
- "Био-анагаах судлаач" мэргэжилтэн нь мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшин зургаан чиглэлээр ажиллах бүрэн цогц чадамжтай.
- "Био-анагаах судлаач" мэргэжилтэн бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөр нь нийт 164 (68+96) багц цагийн багтаамжтай, 5 (2+3) жилийн сургалтын хөтөлбөр юм.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулан хичээлийн төгсгөлд хүрэх үр дүнг Блумын таксиномын 6 түвшинтэй уялдуулан нийт 251 мэдлэг, 195 чадвар, 144 хандлага болгон шинэчилсэн боловсруулсан.
- Сургалтын хөтөлбөрийн хувьд төгсөгчийн загварыг боловсруулан батлуулсан.
- Технологи ашиглалтыг нэмэгдүүлж цахим сургалтын үр дүнг дээшлүүлсэн.
- Хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгож, үнэлгээний арга хэлбэрийг нарийн тусгасан, үнэлгээний аргуудыг суралцахуйн үр дүн бүрээр тодорхой гаргасан шалгуур хуудсыг боловсруулан хэрэглэж байна.
- Түшиц эмнэлэг, эрүүл мэндийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран төгсөлтийн өмнөх сургалтын дадлагын хичээл, зуны дадлага ба дипломын

- ажил бичих зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
- Нийт 4 жилийн хугацаанд нийт 16 хичээлээс 6 хичээлийг сонгон судлах боломжтой болсон.
 - 2021 онд “Био-анагаах судлаач” мэргэжлийн хөтөлбөрт “Лабораторийн амьтан судлал, био-инженерчлэлийн үндэс, био-анагаахын өгөгдлийн шинжилгээ” зэрэг шинэ хичээлүүдийг хөтөлбөрт нэмж оруулсан.
 - Их сургуулийн Удирдлага мэдээллийн системийн тусламжтайгаар суралцагч тухайн улиралд судлах хичээл, хичээл заах багш, хичээлд хамрагдах өдөр, хичээллэх цагаа сонгон суралцах нөхцөл бүрдсэн.
 - Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш улирал бүр оюутнаас үр дүнгийн судалгаа авч тухайн жилийн амжилт, чанарыг өмнөх жилийнхтэй харьцуулан сайжруулалтыг тогтмол хийдэг.
 - Хөтөлбөрийн үр дүнд суурилан, хичээлийн суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг хичээлийн агуулгын, хөндлөн болон босоо залгамж холбоонд хамаарлын матрицыг боловсруулан уялдааг сайжруулснаар тухайн хичээлийн судлах дамжаа, улирал, хичээлийн хуваарь, анги танхимыг төлөвлөн зохион байгуулдаг байна.

Онцлог зүйл:

- 2023 оны А/09 тоот тушаалаар “Био-анагаах судлаач” мэргэжилтний цогц чадамжийг шинэчлэн боловсруулсан. Үүнд: PLO 1 Шинжээч, PLO 2 Мэдээллийг түгээгч, PLO 3 Хамтран ажиллагч, PLO 4 Менежер, PLO 5 Эрүүл мэндийн зөвлөх, PLO 6 Судлаач
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/168 тоот тушаалаар 164 багц цаг хөтөлбөрийн агуулгыг өөрчилсөн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Мэргэжилтэн хөтөлбөрийн агуулгыг ижил төсөөтэй гадаадын 8 их сургууль, дотоодын 2 их сургуулийн хөтөлбөрүүдтэй харин хичээл бүрийн агуулгын төсөөтэй болон ялгаатай талуудыг гадаадын 7 их сургуультай тус тус харьцуулан 2021 оны сургалтын хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт оруулсан.
- 2019 онд лабораториудад ашиглагдаж буй химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авч ажиллаж байна.

Дүгнэлт:

АШУҮИС-ийн БАС-ийн “Био-анагаах ухаан” бакалаврын сургалтын хөтөлбөрийн сургалтын агуулга нь онол, практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаа холбоотой боловсруулагдсан 24.4% нь ерөнхий суурь, 171% нь мэргэжлийн суурь, 50% нь мэргэшүүлэх, 8.5% нь дадлагажуулах, 164 багц цагийн хичээлээр био-анагаах судлаач мэргэжилтний зайлшгүй эзэмших мэргэжлийн чиглэлийн нийт 151 мэдлэг, 195 ур чадвар, 144 хандлагыг төлөвшүүлэх зургаан цогц чадамжийг олгоход чиглэсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Цаашид “Unimis,tw.xcloud.mn”-программын хөгжүүлэлтийг тогтмол сайжруулан хийх
- Хичээлийн хөтөлбөрийг илүү боловсронгуй болгож, үнэлгээний арга хэлбэрийг суралцахуйн үр дүн бүрээр блумын таксономийн 6 түвшинтэй уяалдуулан боловсруулах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Суралцах үйл ажиллагаа нь оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах, төсөлд суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистой хослуулсан байна. Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи сургалтад нэвтрүүлэн хэрэглэсэн.

- Уламжлалт сургалтын аргаас үр дүнд суурилсан арга зүйд шилжиж PLO, CLO-г тооцсон байна.
- Сургалтын SPICES-T загвар/ зайлшгүй эзэмших мэдлэг, чадвар, хандлага, дадлыг бий болгоход чиглэгдсэн арга зүйгээр зохион байгуулж байна.
- Суралцагчийг хөгжүүлэх арга зүйн сайн. Олон талт сургалтын арга зүй ашиглаж сургалтаа явуулдаг.
- Цахим сургалтаар видео, аудио лекц, даалгавар, Мүүдл систем зэрэг хэлбэрүүдээр оюутнуудад хүргэснээр оюутан өөрөө бие даан суралцах боломж, нөхцөлийг нэмэгдүүлсэн байна.
- Дадлага давамгайлсан, технологид суурилсан сургалтын онцлогтой тул сургалтын орчин нөхцөл маш сайн, бүрэн хангалттай байна.
- БАС-ийн мэргэжлийн 16 тэнхимийн нийт 11 сургалт, судалгааны болон компьютерын 3 лаборатори, 72 анги, 8 лекцийн танхим, гадаад хэлний төв, Био-Анагаахын хүрээлэн, клиникийн эмнэлэг, мэргэжлийн байгууллагууд тэдгээрийн амбулаторийг түшиглэн сургалт явуулж байна.
- 1-2 дугаар дамжаанд онолын хичээлүүд давамгайлж онол, дадлага, семинарийн хэлбэрээр, 3 дугаар дамжаанаас эхлэн мэргэжлийн суурь, мэргэшүүлэх болон дадлагын хичээлүүдийг эмнэлзүйд суурилсан арга барил, лабораторийн хичээлээр дамжуулан зааж байна.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам”-ын 3 дугаар бүлэг “Сургалтын арга хэлбэр”-т лекцийн хичээл, дадлага, семинар, бататгах, бие даалтын хичээлийн технологийг сургалтад хэрэгжүүлж, хичээл хөтлөн явуулах замын зургийг мөрддөг байна.
- “Био-анагаах судлаач” оюутны сэтгэл ханамжийн судалгаанаас удирдлага зохион байгуулалт, хөтөлбөрийн агуулга, багшийн заах арга зүй, багш нарын мэдлэг, ур чадвар сайн байна.
- Ажил олгогч нараас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар “Био-анагаах судлаач” мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлагад сэтгэл хангалуун байдаг бөгөөд 86.7% нь АШУҮИС төгссөн төгсөгчдийг ажилд авах сонирхолтой байдаг.
- Цахим ба богино хугацааны мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг давтамжаар зохион байгуулахаас гадна сургалтын арга зүй дээр үндэслэн эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн байна.

Онцлог зүйл:

- Сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдээр оюутнуудад мэдлэг ур чадварыг 3 үе шаттайгаар эзэмшүүлж байна. Үүнд: ерөнхий суурь мэдлэг, ур чадвар олгох сургалт, эмнэлзүйн үндсэн мэдлэг, ур чадвар олгох сургалт, өвчтөнд суурилсан эмнэлзүйн ур чадвар олгох сургалт
- Онлайн лекцийн материал, видео бичлэг, сорил, бие даалт, явцын болон эцсийн шалгалтын материалуудыг сургалтын хөтөлбөрийн дагуу бэлтгэн системд байршуулан хяналт тавин ажиллаж байна.
- Цахим ном-1500, мультмедиа-9805, эрдмийн бүтээл-4000, цахим лекц-226, цахим сэтгүүл-127, сэтгүүлийн 38 дугаарын 1710 өгүүлэл байна.
- Цахим хичээлийн нийт лекц-891, дадлага семинарын хичээл-1855, даалгавар-2118, сорил тохиолдол-5009 бүртгэгдсэн байна.

Дүгнэлт:

“Био-анагаах ухаан судлаач” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, дэвшилтэт технологи ашиглан олон арга зүйгээр сургалт зохион байгуулж байна. Сургалтын шинэ технологийг лабораторийн орчин үеийн хөгжил дэвшилтэй хослуулан дадлага, семинарын хичээлд хэрэглэж буй сурган заах аргууд нь оюутанд мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд бүрэн хэрэглэгдэж байна. Монгол-Японы эмнэлгийн үйл ажиллагаа жигдэрсэн, Био-Анагаахын Хүрээлэнг 2022 онд байгуулж лабораторид ажиллах, дадлагажуулах, сургалтад ашиглах, судлаач оюутан бэлтгэх нөхцөл бололцоог бүрэн цогцоор хангасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Эмнэл зүйн хичээлийн хувьд лабораторийн шинжилгээнд үнэлэлт, дүгнэлт, тайлбарлал өгөх чадварыг илүү эзэмшүүлэх хэрэгтэй.
- Багш нарын хэрэглэж буй сургалтын аргууд, сургалтын хүргэх хэлбэрүүдийн хоорондын холбоог сайжруулахын тулд PLO, CLO-н үр дүнг блумын таксономийн 6 түвшин, рубрик үнэлгээг хэрэглээ сайжруулах.
- Олон улсын хөтөлбөр, дадлага солилцоог идэвхжүүлэх хэрэгтэй.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын IV бүлэг баталсан “Үнэлгээний аргачлал”, хоёрдугаар хавсралтаар “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам”-ын V бүлэг “Үнэлгээ”-ний журам оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх аргачлалыг мөрддөг. Журмын хүрээнд хичээлийн хөтөлбөрт оюутныг үнэлэх арга зүй, аргачлал, хэлбэрийг дэлгэрэнгүй тусгасан.

- Суралцагчийн үнэлгээ нь мэдлэг, ур чадвар, хандлагыг дүгнэх үнэлэх, мэдлэг шалгах сорил, гардан үйлдлийн шалгалт, ур чадварыг үнэлэх шалгалт, эмнэлзүйн тохиолдол,

шалгах хуудас зэрэг үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан хичээлийн хөтөлбөрийг сургуулийн захирал, хөтөлбөрийн дэд хороогоор баталгаажуулан хэрэгжүүлдэг.

- Төгсөгчдийн шалгалтад суралцагчдын онолын мэдлэгийг 4 хэлбэрийн 150 сорилоор авах бөгөөд нийт сорилын 40 % нь А хэлбэрийн сорил, 40% нь К хэлбэрийн сорил, 10% нь Е хэлбэрийн сорил, 10% нь В хэлбэрийн сорил байхаар зохион байгуулдаг.
- Төгсөлтийн сорилын эмхэтгэл нь жил бүр 25%-иар шинэчлэгдэн боловсруулагдсан.
- Төгсөлтийн гардан шалгалтад Төлөвлөгдсөн Зорилготой Эмнэлзүйн Шалгалтын аргыг өргөн ашигладаг ба эмнэлзүйн мэдлэг, ур чадварын гүйцэтгэл, хандлагыг өгөгдсөн тодорхой хугацаанд нэгэн зэрэг өргөн хүрээнд үнэлдэг байна.
- Хөтөлбөрөөр суралцагч оюутныг ирээдүйд хамтран ажиллах салбарын мэргэжлийн оюутнуудтай хамтран даалгавар гүйцэтгэх, дадлага хийх нь сайшаалтай.
- Хөтөлбөрийн онцлогт тохирсон оюутныг үнэлэх үнэлгээний систем тогтсон байна.
- Ерөнхий суурь хичээлүүдийн үнэлгээ жил ирэх бүр сорил болон холимог хэлбэр давамгайлж, мэргэжлийн суурь хичээлүүдэд холимог болон сорил харин мэргэшүүлэх хичээлүүдэд холимог, аман, сорил хэлбэр жигд давамгайл байгаа нь харагдаж байна.
- Суралцагч өөрийн сурлагын дүнгийн амжилт, дүнгээ X-CLOUD-программыг ашиглан ил тод, нээлттэйгээр харах боломжтой.

Онцлог зүйл:

- Эмнэлзүйн сургалтад суралцагчийн чадварын түвшнийг чаддаг, хийсэн, харсан, сонссон (Can, Do, Seen, Listen) гэсэн 4 шатлалаар үнэлдэг энэ систем нь сонссон, харсан, хийсэн түвшнийг хичээлийн танхим, сургалтын лабораториудад, чаддаг түвшнийг сургалтын эмнэлэг, лаборатори болон дадлагын байранд явуулдаг байна.
- Мэргэжлийн суурь хичээлүүдэд хандлагыг үнэлэхдээ 360 хэм-ийн үнэлгээний аргыг нэвтрүүлсэн.
- Улирлын төгсгөлд суралцагч өөрийн дүн, үнэлгээг баталгаажуулахаас өмнө хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ болон сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулгад хамрагддаг.
- 2022 онд “Суралцагчийн үнэлгээний журамд” үнэлгээний хэлбэрүүдийг ялган ангилж оруулсан.
- 2023 оноос “Био-анагаах судлаач” хөтөлбөрийн хүрээнд ерөнхий, мэргэжлийн суурь хичээлд тэнхим бүр хуваарьт хичээлүүд дээр корреляцийн матриц байгуулан хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг тодорхойлж эхэлсэн байна.
- Улирлын шалгалт хичээлийн онцлог, агуулгаас хамаарч цахим, цаасан сорил, аман шалгалт, өртөөчилсэн аман шалгалт хэлбэрүүдтэй.
- Төгсөлтийн мэдлэг үнэлэх шалгалтыг 16 хичээлийн агуулгатай 100 сорилоор нэгэн зэрэг таблет дээр автомат засах систем бүхий программаар авдаг бол ур чадварын шалгалтад мэргэшүүлэх хичээлийн хүрээнд 7 өртөөгөөр тохиолдол дээр ажиллуулан авдаг.
- 2019-2021 оны бүх төгсөгч нар мэдлэг, ур чадвар, диплом хамгаалалтын 3 шалгалтуудыг өгч төгссөн. 2022 оноос төгсөгчдийн тоо нэмэгдэж, диплом хамгаалалт буурсан нь танхимын сургалт эхэлсэнтэй холбоотой байна.

- 2022-2023 онуудад хичээлийн жилд Био-анагаах судлаач мэргэжлээр суралцагч буй төгсөгч нараас хүсэлтийг харгалзан үзэж зөвхөн ур чадвар болон диплом хамгаалахын аль нэгээр сонгуулж төгсөлтийн шалгалтыг дүйцүүлэх болсон.
- 2023 онд Эрдмийн чуулган-65 Боловсрол судлалын салбар хуралдаанд АУ-ы боловсрол судлалын чиглэлээр 61 илтгэл ирсэн байна.
- Суралцагч оюутны лабораторит эзэмшсэн ур чадвар, судлаач болох мэдлэг, чадвар, хандлага сайжирсан нь 2022 онд 2.7 дахин нэмэгдсэн төсвийн зарцуулалт илтгэж байна.

Дүгнэлт:

Суралцагчийн үнэлгээг мөрдөж буй журам, дүрмийн хүрээнд байнга шинэчлэн, тухайн хичээлийн онцлогт тохируулан үнэлгээний аргыг боловсруулан оюутны үнэлгээ хийгдэж байна. “Био-анагаах ухаан судлаач” бакалаврын сургалтын хөтөлбөр нь суралцагчид 6 цогц чадамжийг эзэмшүүлэхээр хичээл бүр нь мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, түүнийг тасралтгүй сайжруулалт хийдэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- “Био-анагаах ухаан судлаач” хөтөлбөрийн үр дүн болох мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох даалгаврын санг Блүүмийн таксаномын 6 түвшингээр тодорхойлох, дамжаа бүрд даалгаврын сангийн үнэлгээний блюпринтийг тодорхойлох

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн төв байранд 85 анги танхим, 10 сургалт судалгааны лаборатриуд, Био Анагаахын хүрээлэн, Монгол -Япон эмнэлгийн клиник лабораторийг сургалтын болон судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглаж байна. Сүүлийн 5 жилд урсгал засварт 250,3 сая, үндсэн хөрөнгөнд 784 сая, жижиг эд хогшилд 21,7 сая төгрөг зарцуулсан. 2023 оны 3, 4 улиралд 300 сая төгрөгийн 1 ш смарт дэлгэц, 48 ш компьютер, 10 ш зөөврийн компьютер, 12 ш 65 инчийн TV, 5 ш проектор худалдан авч тэнхимүүддээ тарааж сургалтын орчинг сайжруулсан.
- 2023 оны 12 сарын 12 байдлаар 2950 нэр төрлийн 1,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө АШУҮИС-ийн төв байранд байрлах тэнхимүүдэд бүртгэлтэй байна.
- Багш нар сургалтын төлбөрөөс орох орлогын тодорхой хувийг лабораторийн тоног төхөөрөмж, урвалжийг захих зорилгоор захиран зарцуулах эрхтэй. Хэрэгцээтэй багаж

тоногт төхөөрөмжийг тэнхимийн хурлаар хэлэлцэж, санал төсөл боловсруулж, харьяа сургуулийнхаа захиралд танилцуулж, санхүүжилтийг батлуулдаг.

- АШУҮИС нь улсын болон улирлын шалгалт авах үед оюутнуудыг лекцийн том зааланд оруулж, Багшийн хөгжил, цахим сургалтын газар 140 таблет тарааж, шалгалтаа авдаг. Интернэтийн хурдыг жил бүр нэмж байна. Интернэтийн найдвартай байдлыг Цахим хөгжил, маркетингийн газрын Мэдээлэл Технологийн Төв хариуцан ажилладаг.
- XCloud University system -ийг багш нар, SW.XCloud.mn хаягийг оюутнууд ашигладаг.

Онцлог зүйл:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 оны 10 сард 2 төв, 5 төрөлжсөн лабораторитой “Био -Анагаахын хүрээлэн” шинээр байгуулагдсан. Үндсэн зорилго нь Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг тогтоож салбар дундын суурь судалгааны төслүүдийг хамтран гүйцэтгэх магистр, доктор, судлаач, мэргэжилтнүүдийн хөгжих боломжийг нэмэгдүүлэх болон бусад нөөц бололцоог төвлөрүүлэн ажиллах. Энэ хүрээлэнд электрон бичил харуур гэх мэт хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүд ашиглаж байна.
- “Биологи, экологийн үзвэрт танхим”-ийг 2019 онд тохижуулан биологи, экологи, шимэгч судлалын дадлагын хичээлийн сургалт явж байна.
- АШУҮИС-ийн харьяа Монгол-Японы эмнэлгийн Эмнэлзүйн төв лаборатори нь БАС-ийн оюутнууд сургалт явуулах, дадлага хийх нөхцөл бүрдүүлэн ажиллаж байна.
- Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авсан.

Дүгнэлт:

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай Сургалтын орчинг бүрдүүлсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хэт хуучин загвартай, ашиглах боломжгүй багаж тоног төхөөрөмжүүдийг актлах.
- Төв болон төрөлжсөн лабораториудад ашиглаж байгаа өндөр үнэтэй багаж төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулахад шаардлагатай засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн зардлыг улирал бүрээр гарган ханган ажиллах нэгдсэн төлөвлөгөө гаргах.
- Өндөр хүчин чадалтай, сүүлийн үеийн багажуудыг бүрэн хүчин чадлаар нь үр дүнтэй ашиглах ажиллуулахад анхаарах.
- Тодорхой урсгал зардлаа төлөн судлаачид, судалгааны багууд БАХ-д ажилуулах боломж эрх зүйн орчинг улам сайжруулах төлөвлөгөө гарган ажиллах,
- Дараагийн 2024-2029 оны 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гаргах.
- АШУҮИС дэлхийн шилдэг 1000 сургуулийн нэг болоход хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөлийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог тав таван жилээр гаргадаг болох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Дадлагын хичээлд ашиглах урвалж, хэрэглэгдэхүүнийг жил бүрийн төсөвт “Хичээл практикийн зардал” нэртэйгээр тусган, худалдан авч, дадлага хичээлүүдэд хэрэглэдэг.
- АШУУИС нь цахим сургалтыг хөгжүүлэх зорилгоор Төгсөлтийн Өмнөх Сургалтын Бодлого Зохицуулалтын Газрын дэргэд 2015 онд “Цахим сургалтын төв” шинээр нээсэн. 2021 оноос Багш хөгжил, Цахим Сургалтын Газрыг байгуулж, цахим сургалтын төв тус газарт харьяалагддаг болсон. Цахим сургалтын төв нь интернэт протокол хаягийг ашиглан хөдөө, орон нутгийн 3 салбар сургууль, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагууд, гадаадын хамтын ажиллагаатай их сургуулиудтай шууд холбогдох онлайн хурлын төхөөрөмжтэй.
- “АШУУИС-д Цахим сургалт эрхлэх журам”-ыг анх 2016 онд баталсан. Тус журмыг шинэчлэн АШУУИС-ийн захирлын 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар “АШУУИС-ийн Сургалтын технологи, чанарын хяналтын журам”-д бүлэг болгон баталж, сургалтын үйл ажиллагаанд мөрдлөг болгож байна.
- Цахим сургалтын төв нь 2020-2021 оны хичээлийн жилээс оюутнуудад зориулсан онлайн хичээл бэлтгэж, цахим сургалт явуулахад зориулагдсан eMNUMS аппликэйшн (<http://elearning.mnums.edu.mn/>) нэвтрүүлсэн. Энэхүү аппликэйшнийг ашиглан цахим сургалтын системд бүртгүүлэх, нэвтрэх, хичээлийн контентуудыг үзэх, зарим контентыг онлайн үзэх, хичээл хайх, бусад хэрэглэгчидтэй харилцах, мобайл төхөөрөмжөөс зураг, аудио, видео болон бусад файлаа байршуулж, хадгалах болон өөр нэмэлт олон боломжийг ашиглаж суралцах, давуу талтайгаас гадна цахим хэлбэрээр шалгалтаа өгөх боломжтой.
- Био-анагаах судлаач бэлтгэх сургалтын хөтөлбөр дэх хичээлүүд, тэдгээрийн агуулгаар
Е-контент бэлтгэн, цахим сургалтын орчинд байршуулан, хичээлд ашигладаг.
<http://elearning.mnums.edu.mn/>
 - I дамжаанд заагддаг 17 хичээлийн 91 лекц, 12 дадлага семинар, 12 сорил
 - II дамжаанд заагддаг 19 хичээлийн 171 лекц, 39 дадлага семинар, 15 сорил
 - III дамжаанд заагддаг 15 хичээлийн 118 лекц, 8 сорил
 - IV дамжаанд заагддаг 12 хичээлийн 107 лекц, 14 семинар, 1 сорил
 - V дамжаанд заагддаг 10 хичээлийн 90 лекц, 8 семинар, 1 сорил буюу нийт - 73 хичээлийн 577 лекц, 73 семинар, 37 сорил бүхий сургалтын хэрэглэгдэхүүнийг онлайн ашиглаж байна.

Онцлог зүйл:

- Elearning системд байршуулсан сургалтын материалуудыг дахин хэдэн удаа ч, хэзээ ч үзэх боломжтой.
- Цахим хичээлийн дуу болон дүрс бичлэгийг чанартай бэлтгэх зорилготойгоор бүрэн тоноглогдсон дуу бичлэгийн “Мультимедиа студи” -ийг 2017 онд байгуулсан. “Мультимедиа студи”-д цахим хичээлийн контент бэлтгэхээс гадна их сургуулийг

сурталчлах видео, аудио бичлэгүүд, реклам сурталчилгаа хийх, мөн захиалгаар бусад үйлчилгээг үзүүлэх боломжтой.

- Сурах бичгийг байнга сайжруулж, сүүлийн үеийн техник технологийг амжилттай ашиглаж байна.

Дүгнэлт:

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн бүрдүүлсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэгдхүүний хүртээмжтэй байдалд үнэлгээ хийх, суралцагчийн тоотой харьцуулж, хүртээмжтэй болон чанартай эсэхэд анхаарах.
- Сургалтын бааз болон сургуулийн эмнэлэг дээр багш, оюутнуудын хэвийн ажиллах нөхцөл бүрдүүлэх, өртөг үр дүнгийн шинжилгээг тогтмол давтамжтай хийж байнгын сайжруулалт хийх ажилд хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Био-Анагаах судлаач хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлд 349 төрлийн 4030 ширхэг, мэргэжлийн хичээлд 135 төрлийн 2584 ширхэг ном, сурах бичиг уншлагын танхимд байгаа нь оюутан тус бүрд хүртээмжтэй байдаг.
- Био-Анагаах судлаач хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлд 36 төрлийн 109 ширхэг, мэргэжлийн хичээлд 36 төрлийн 193 ширхэг гарын авлага, дадлага, семинарын хичээлийн удирдамж, 18 зургийн цомог, 734 толь бичиг уншлагын танхимд байгаа нь оюутан тус бүрд хүрэлцээтэй байна.
- 2022 онд Био-Анагаах судлаач хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын санал хүсэлтээр англи хэл дээр бичигдсэн 7 хичээлийн 18 сая төгрөгийн үнэтэй 48 ширхэг мэргэжлийн үндсэн сурах бичгийг худалдан авсан. Харин 2023 онд 6 хичээлийн 21 сая төгрөгийн үнэтэй 39 ширхэг, нийт 87 ширхэг мэргэжлийн үндсэн сурах бичгийг шинээр захиалан авсан.

Онцлог зүйл:

- ЭМШУТНС-гийн <http://library.mnums.edu.mn> электрон каталог нь 30,268 төрлийн ном товхимол, 2,667 эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, 2,333 цахим материал, 2,127 лавлагааны материалтай. Электрон каталогид сард дунджаар 6,297 хэрэглэгч хандаж, 29,130 удаа хайлт хийж, 20,284 удаа цахим ном уншдаг байна.
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны төв номын сан нь багш оюутнуудын цахим номын сангийн эрхийг идэвхжүүлж, цахим номын сангийн үйлчилгээг нээсэн. Багш

оюутнуудын цахим номын санд нэвтрэх эрх нээх, нууц үг сэргээх санал хүсэлтийг library.support@mnums.edu.mn тусгай э-мэйл хаяг нээн хүлээн авч шийдвэрлэдэг.

- Олон улсын мэдээллийн сүлжээ, нээлттэй эх үүсвэр ашиглах боломж АШУҮИС-ийн багш, судлаач, оюутан 2006 оноос Research4life (HINARI) цахим мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглах боломж олгосон. Research4life цахим мэдээллийн сан нь шинжлэх ухааны олон салбарын хэвлэн нийтлэгч, мэргэжлийн холбоо, судалгааны байгууллагуудаас эрхлэн гаргадаг 140,000 гаруй эрдэм шинжилгээний сэтгүүл, 56,000 гаруй цахим ном бусад мэдээллийн эх сурвалжуудыг багтаасан олон улсын цахим мэдээллийн сан юм.
- АШУҮИС нь 2018 оноос сургалт судалгаанд дараах программуудыг ашиглаж байна. Үүнд:
 - Koha (цахим номын сангийн программ)
 - Moodle (Суралцагчдын программ)
 - Microsoft 365 education
 - Gsuite (цахим шуудан)

Дүгнэлт:

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай номын сан, мэдээллийн эх үүсвэр хангалттай байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Номын фонд хадгалах зай тайлбайг шат дараатай бий болгох, хадгалалт галын аюулгүй байдлыг хангах
- Магистр, докторуудын бүтээлийг цахим хэлбэрээр хадгалах, үзэх боломжийг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэцийн хэрэгцээг гарган үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Био-анагаах судлаач хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO) тодорхойлсон
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулсан байна.

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, хоёрдугаар хавсралтаар Сургалтын технологи, чанарын хяналтын журамтай байна.
- Тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Био-Анагаахын сургуулийн захирлаар удирдуулсан хөтөлбөрийн дэд хороо, тэнхимийн эрхлэгчид ажилладаг.
- Оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан мэргэжлийн хөтөлбөр болон нэгж хичээлийн хөтөлбөрийг шинэчилдэг байна. Ингэхдээ тухайн хичээлийн хөтөлбөрийн 30% тэй тэнцэхүйц өөрчлөлт орсон үед шинэчлэн боловсруулдаг байна.
- Хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2021 оны 10 дугаар сарын 01 өдрийн А/204 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан байна.
- Био-анагаах судлаач хөтөлбөрийн хүрэх үр дүн болох (PLO) 6 багц, 14 ур чадварт анализ хийх, дамжаа бүрд эзэмших чадамжийг тодорхойлон гаргаж, био-анагаах судлаач мэргэжилтний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлон гаргасан байна.
- АШУҮИС-ийг хөгжүүлэх 2015-2024 оны стратегийн хүрээнд богино хугацааны, 2030 он хүртэл хэрэгжүүлэх стратегийн бодлогод урт хугацааны төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж байна.
- Био-анагаахын судлаач хөтөлбөрийн тайланг АШУҮИС-ийн менежерийн үр дүнгийн гэрээтэй хамт 2018, 2019, 2020 онд нэгдсэн байдлаар хийдэг байсан бол 2021 оноос эхлэн салбар сургуулиар үр дүнгийн тайлан гаргадаг болсон нь ахиц дэвшлийг харж дүгнэх, цаашдын шинэчлэлийг хийх бүрэн боломж олгосон байна.
- Хичээлийн жилийн туршид оюутны санал хүсэлтийн өөрийн сургуулийн мэргэжилтэн, арга зүйчид дээр хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэдэг.
- Сургуулийн багш, ажилчид, оюутан суралцагчтай холбоотой санал гомдол нь АШУҮИС-ийн захирлын 2018 оны 10 сарын 08 өдрийн А\142 тушаал, 2021 оны 10 сарын 13 өдрийн А\214 тушаалуудаар батлагдсан ёс зүйн зөвлөлд хүрч, 2022 оны 03 сарын 14 өдрийн А/37 тушаалаар батлагдсан ёс зүйн журмаар зохицуулагддаг байна.
- Удирдлага мэдээллийн системийн хувьд Админы програм, Монитор програм www.monitor.xcloud.mn, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын албаны програм www.main.xcloud.mn, Багшийн програм www.CloudUniversity - Teacher IDP, Оюутны програм www.student-web.xcloud.mn зэрэг програмыг ил тод нээлттэй ашигладаг байна.

Онцлог зүйл:

- Био-анагаахын судлаач хөтөлбөрийн тайланг АШУҮИС-ийн менежерийн үр дүнгийн гэрээтэй хамт 2018, 2019, 2020 онд нэгдсэн байдлаар хийдэг байсан бол 2021 оноос эхлэн салбар сургуулиар үр дүнгийн тайлан гаргадаг болсон.

Анхаарах асуудал:

- Багш, оюутны санал, гомдол авдаг цэсийг сургуулийн пэйж дээр байрлуулах. (QR)
- Ирсэн санал, гомдлыг хүлээж авч, нэгтгэн, мэдээлдэг, тайлагнадаг албан тушаалтан томилох, холбогдох нэгжүүд хэрхэн шийдвэрлэсэн тухай эргэж мэдээллэх, тайлагнах зэрэг эргэх холбоотой ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөгжлийн стратеги төлөвлөгөөг гаргаж, хүрэх үр дүн тооцдог байх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотоодын 17 эмнэлэг, гадаадын 14 сургуультай хамтын ажиллагаатай ажиллаж байна.
- АНУ-ын BYU Hawaii Их сургууль, Нагояа, Токушима, Жичи их сургуулиудтай багш, оюутан солилцооны 5 хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Хамтарсан төсөлт ажил 4-ийг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд уран зохиол, сурах бичиг бүхий 167 номын фондтой болсон байна.
- Нийгэмд чиглэсэн 5 төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.
- Био Био-Анагаахын сургуулийг 2007-2009 онд Спортын эмч мэргэжлээр төгссөн 45 төгсөгчдийн уулзалт зохион байгуулж, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгахтай холбоотой хүсэлтийг хүлээн авч, АШУҮИС-ийн Хөтөлбөрийн хорооны хурлаар санал оруулж хэлэлцүүлэн давтан сургалтыг зохион байгуулж эхэлсэн байна.
- Давтан сургалтад 2022 онд 63 мэргэжилтэн хамрагдсан байна.

Онцлог зүйл:

- Мультимедиа технологийг сургалтад ашигладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн онцлог, ач тус, мэргэжилтний ирээдүйн эрэлт, хэрэгцээний талаар төгсөгчид, ажил олгогчид болон олон нийтэд үнэн зөвөөр сурталчилан, таниулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Холбогдох эрх бүхий байгууллагуудад тус хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжилтний хөгжлийн загварыг шинэчлэн боловсруулж, албан тушаалын тодорхойлолтод хамруулж, хууль эрх зүйн чадамжтай болгох талаар санал хүргүүлж, төгсөгчдийн эрх ашгийн төлөө хамтран ажиллах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн санхүүжилт ба орлого 2018 онтой харьцуулахад 2023 онд 32 хувиар өссөн дүнтэй байна.
- Нэг оюутанд ноогдох зардлыг 2018 онтой харьцуулахад 2023 онд 63 хувиар буурсан байгаа нь цар тахалтай холбоотой байна.
- Нийт зардлыг 2018 онтой харьцуулахад 2023 онд 62 хувиар өссөн дүнтэй байна. Харин хөтөлбөрт чиглэгдсэн зардал 32 хувиар буурсан үзүүлттэй байна.

Анхаарах асуудал:

- Үндсэн орлогоос гадна бусад нэмэлт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Нийт орлогоос багш, оюутны хөгжилд хэдэн хувийг зарцуулах эсэхийг тодорхой болгох

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтад зарцуулах зардлыг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт
Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд био-анагаах судлаач мэргэжлээр суралцагсдын тоо тогтмол нэмэгдсэн байна.
- Анхны элсэлтийн тоотой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.
- Элссэн оюутны тоог төгсөгч оюутны тоотой харьцуулахад 2014-2018 онд 80 хувь байсан бол 2018-2022 онд 65 хувь байна.
- Оюутны шилжилт хөдөлгөөний шалтгааны 58 хувь нь жилийн чөлөө, 31 хувь нь ангиа сольсон, 11 хувь сургуулиас гарсан байна.
- Ажил олгогчдоос авсан судалгааны дүнгээс харахад төгсөгчид ажлын байранд тавигдах шаардлагад нийцэж буй эсэхт 80 % нь нийцдэг гэсэн байна.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаагаар 2021 онд 86.7% байсан бол 2023 онд 93.8% болж 8.2% иар өссөн байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 2018 онд 70.7 % байсан бол 2023 онд 100% болж 41% иар өссөн байна.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа 2018 онд 41 хувь байсан бол 2023 онд 56 хувь болж 36.6% иар өссөн байна.

Онцлог зүйл:

- Оролцогч талуудын сэтгэл ханамж өссөн сайн дүнтэй байна.

Анхаарах асуудал:

- Элсэгч, төгсөгчийн харьцааг ойртуулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутны шилжилт хөдөлгөөний шалтгаан дээр анхаарч ажиллах
- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц хөтөлбөр, төлөвлөгөө гарган, хяналтын тогтолцоо бүрдүүлэн ажиллах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2020 оны хичээлийн жилээс эхлэн оюутан залуучуудад зориулсан мэргэжил сурталчлах болон ёс зүй хүмүүнлэг харилцаа сэдэвт лекц уншдаг байна.
- Био-анагаахын багш нар хөдөө орон нутгийн ерөнхий боловсролын сургуульд очиж мэргэжил сурталчлах лекц уншдаг байна.
- Био-Анагаахын оюутны зөвлөлөөс жил бүр Био-Анагаах судлаач мэргэжлийг сурталчлах өдөрлөг зохион байгуулдаг.
- АШУҮИС-ийн үндсэн вебсайт дээр Био-Анагаахын сургуулийн багш нар био-анагаах судлаач мэргэжлийг сурталчилсан подкаст, видеог нээлттэй байршуулдаг. (https://www.youtube.com/watch?v=u_VBIKNRtr8).

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн тогтвортой байдал, мэргэжилтний эрэлт хэрэгцээний талаар олон нийтэд таниулах
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, сэтгэл ханамж, ажлын байраар хангагдах боломж зэрэгт тогтмол судалгаа явуулж, санал, хүсэлт, сэтгэгдлийг ажил хэрэг болгон ажиллах тал дээр анхаарах

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Био-анагаах судлаач мэргэжилтний үнэ цэн, мэргэжлийн онцлогийг оюутан, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчдод ойлгуулах, сурталчлах ажлыг түгээн дэлгэрүүлэх

Дүгнэлт:

Хөтөлбөрийг удирдлага мэдээллийн системээр хангаж ажиллаж байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, БСШУ-ны сайдын 2018 оны А/194 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Босго оноо тогтоох тухай” А/195 тоот тус тус тушаалд үндэслэсэн АШУҮИС-д “Оюутан элсүүлэх журам”-аар элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Элсэлтийн журам, элсэлттэй холбогдох нэмэлт мэдээллийг www.mnums.edu.mn сайтын “элсэлт” цонхонд нэвтэрч орсноор “шинээр элсэх, элсүүлэх мэргэжлүүд, оюутан элсүүлэх журам, бүртгүүлэхэд анхаарах зүйлс, заавар, онлайн элсэлт, АШУҮИС-ийн элсэлтийн facebook, нэмэлт элсэлт, гадаад оюутан сонгон шалгаруулах ба суралцуулах” тус тус чиглэлээр мэдээлэл авах боломжтой.
- Био-анагаах судлаач хөтөлбөрөөр элссэн элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо өссөн үзүүлэлттэй. Тухайн мэргэжлээр хүсэлт гаргасан элсэхийг хүсэгчдийн тоо их байгаа нь АШУҮИС-ийн нэр хүнд, сургалтын чанар сайн байгаатай холбоотой гэж дүгнэж байна. Босго оноо 480 байгаа боловч тухайн мэргэжилд илүү өндөр оноотой оюутнууд элсэн орсон байна.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн цахим сургалт-маркетингийн газар, Оюутны хөгжил удирдлагын газартай хамтран элсэгчдэд зориулсан элсэлтийн болон мэргэжил сонголтын талаарх мэдээлэл, Био-Анагаах судлаач мэргэжлийн танилцуулах зэрэг маркетинг хөгжүүлэлийн ажлуудыг тасралтгүй хийдэг.
- Нийт 94 гадаад оюутан 2017-2021 онуудад элсэн суралцсан байна.

Дүгнэлт:

Суралцагч сонгох, элсүүлэх ажил шаардлага хангах хэмжээнд байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Элсэлтийн тоог зах зээлийн хэрэгцээ шаардлыг зохих байгууллагуудтай хамтран тодорхой давтамжтай судлан, тогтоодог болох.
- Шаардлагатай байгаа дунд мэргэжилтний судалгаа гарган элсэлтийн тоог нэмэгдүүлэх (лабораторийн технологч гм,). Зах зээлд шаардлагатай байгаа мэргэжлүүдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан элсэлт авах (флиботомист - Phlebotomist гм)

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Био-анагаах судлаач оюутнуудын мэргэжлийн чиглэлийн зөвлөн туслах үйлчилгээнд тэнхимийн эрхлэгч болон профессорын багийн ахлагч нар тус тус хяналт тавин тэнхимийн багш нар оролцон хамтран ажилладаг. Био-анагаах судлаач оюутнууд мэргэжил, арга зүй болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллахдаа ажил олгогчидтой нягт хамран ажиллаж зөвлөн туслах үйлчилгээг хүргэдэг.
- Оюутны хөгжил, удирдлагын газар нь оюутны нийгмийн болон хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг хариуцаж, оюутны элсэлт, сурлагаас бусад шалтгаантай холбогдолтой шилжилт хөдөлгөөн, анги хэсэгт хуваарилах, цахим бүртгэлд оруулах, дүрэм журамтай танилцуулах, суралцах гэрээ байгуулах, тангараг өргүүлэх, төлбөрийн зээл, тэтгэлэгт хамруулах, оюутнуудад чиглэсэн орлоготой оюутан зэрэг олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутан суралцагчидтай холбоотой ой, өдрийн арга хэмжээ зохиох, клубүүдийн үйл ажиллагааг зохицуулах зэргээс гадна дотуур байранд амьдарч буй оюутнуудын амьдрах орчныг хянах, санал хүсэлт авах, сайжруулах ажлыг хийдэг.

2021 оноос эхлэн энэхүү алба нь Оюутны хөгжил, удирдлагын газар болон өргөжиж АШУҮИС-ийн нийт оюутанд чиглэсэн тасралтгүй хөгжих, суралцах үйл явц, тэдний эрх ашгийг хамгаалах, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, тэтгэлэг хөтөлбөрт хамруулах, элсэлт төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Онцлог зүйл:

- 2021-2022 оны хичээлийн жилээс "Оюутны хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэсэн байна. Энэхүү хөтөлбөр нь "Эх оронч оюутан", "Эрүүл авьяаслаг оюутан", "Хөдөлмөрч оюутан", "Үлгэрлэгч оюутан" гэх үндсэн 4 чиглэлээр хэрэгжиж буй бөгөөд ёс зүйтэй, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, харилцаа хандлагын өндөр соёлтой, олон талт авьяас чадвартай, гоо зүйн мэдрэмжтэй, бүтээгч хөдөлмөрч, хувь хүний хувьд өөрийгөө хөгжүүлсэн, эрүүл, эрч хүчтэй, эх оронч бие хүн болон төлөвшүүлэх зорилготой.
- Био-анагаах судлаач хөтөлбөрөөр суралцагчид нь мэргэжлийн сэдвээр гүнзгий мэргэших, онолын мэдлэг болон эзэмшсэн арга зүйгээ судалгаа, шинжилгээний ажилд ашиглах чадвараа нэмэгдүүлэх, судлаач болох зорилгоор төгсөлтийн дипломын ажлыг удирдамжийн дагуу бичиж эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хамгаалдаг. 2017-2022 онуудад нийт төгссөн оюутны 56,9 хувь (132/232) дипломын ажил бичиж хамгаалсан.
- Харилцааны ур чадварын тэнхим байгуулсан.

Дүгнэлт: Зөвлөн туслах үйлчилгээ хангалттай хийгдэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын ач холбогдлыг сурталчилж суралцах хүсэлтэй оюутны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллах

- Одоо мөрдөгдөж байгаа БАС-ын ажлын байрны талаарх тушаал, шийдвэр, дүрэм стандартуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж төгсөгчид бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэх.
- Эрүүл мэндийн байгууллагын удирдлага болон хүний нөөцийн мэргэжилтэнд зориулсан 4 цагийн Био-анагаах судлаач мэргэжлээр төгсөгчдийн чадвар, хийж чадах ажлуудын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, тэдэнд тодорхой давтамжтай сургалт явуулах төлөвлөгөө гарган ажиллах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдыг амжилттай суралцах, урлаг, спорт болон бусад чиглэлээр бүтээлчээр хөгжих боломж олгох, дэмжих зорилгоор Оюутны холбоо, клубүүдийн бие даасан үйл ажиллагааг дэмжин удирдлага, зохион байгуулалт, төсөв хөрөнгөөр ханган тасралтгүй хамтран ажиллаж байна.
- Нийт 20 гаруй клубүүд, дугуйлангийн үйл ажиллагааг мэргэжлийн тэнхим бүрийн багш нар удирдан чиглүүлж хамтран ажилладаг.
- АШУҮИС-ийн Оюутны холбооны дэргэдэх Био-Анагаахын Сургуулийн Оюутны Нийгэмлэг нь хичээлийн жилийн турш тогтмол үйл ажиллагаа явуулан, оюутан бүрд хүрч ажиллахыг хичээн ажиллаж байна.
- Жил бүр оюутнуудын нийтийн тээврээр зорчих карт захиалга болон олголт, “Номын солилцоо” аян, БАС-ийн I-V дамжааны оюутнуудын дунд “Танилцах зугаалга” арга хэмжээ, “Спортын бага наадам”, “Витаминжуулалтын аян”, Сайн үйлсийн аян, ЦССТөвтэй хамтран “Цусны донор” өдөрлөг, Премедикалын I, II дамжааны оюутнуудад зориулан “Мэргэжил сурталчлах” лекц, БАС-ийн “Оюутны эрдэм шинжилгээний бага хурал” зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулдаг.
- “Эко” цогцолборт Оюутны Холбооны төв байрыг тохижуулсан ба энэ нь оюутнуудад илүү ойртож, үйл ажиллагаа зохион байгуулахад хамрах хүрээ их, үр дүн сайжрах нөхцөл бүрэлдсэн байна.
- 2017 онд АШУҮИС-ийн захирлын 2017 оны А/127 дугаар тушаалаар олгосон тэтгэлэгт Био-Анагаахын сургуулийн “Сурлагын амжилт” чиглэлээр 16 оюутан, “Нийгмийн халамж, идэвх” чиглэлээр 7 оюутан хамрагдсан байна.
- 2018 онд АШУҮИС-ийн захирлын 2018 оны А/144 дүгээр тушаалаар олгосон тэтгэлэгт Био-Анагаахын сургуулийн 11 оюутан “Сурлагын амжилт” чиглэлээр, 5 оюутан “Нийгмийн халамж, идэвх” чиглэлээр тус бүр 500.000 төгрөгийн тэтгэлэг авсан байна.
- 2019 онд АШУҮИС-ийн захирлын 2019 оны А/104 дүгээр тушаалаар олгосон тэтгэлэгт Био-Анагаахын сургуулийн 27 оюутан хамрагдсан. АШУҮИС-ийн захирлын 2019 оны А/388 дүгээр тушаалаар олгосон тэтгэлэгт Био-Анагаахын сургуулийн 17 оюутан хамрагдсан.

Онцлог зүйл:

- Суралцагчийн сурах идэвх сонирхлыг өрнүүлэх, онолын болон практик мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн хөгжүүлэх, түүнчлэн урлаг, спортын авьяас чадварыг нээн

илрүүлэх, хөгжүүлэн сайжруулах, бусадтай мэдлэг туршлагаа солилцон хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тэмцээн уралдаан зохион байгуулах, баг бэлтгэн оролцуулах, оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх, дэмжин туслах зэргээр ажиллаж байна.

- Био-Анагаахын сургуульд суралцагсдыг оюутны хөгжлийн зээлд хамрагдахад дэмжин ажилладаг.
- 2014 оноос "Оюутны эрүүл мэндийг дэмжих төв"-ийг нээн оюутнуудын эрүүл мэндийг дэмжих, амьдралын зөв хэв маяг хэвшүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчилсөн тохиолдолд үзлэг оношилгоог хийж, дараагийн шатлалын эмнэлэг рүү чиглүүлэн туслах үйлчилгээг үзүүлсэн. 2022 онд тус оюутны төв нь АШУҮИС-ийн захирлын А/206 тоот тушаалаар АШУҮИС-ийн Төв эмнэлгийн харьяанд шилжин үйл ажиллагаа явуулж байна.
- 2019-2020 оны хичээлийн жилд АШУҮИС-ийн 1-р дамжаанд элссэн бүх мэргэжлийн чиглэлийн 1355 оюутнуудыг урьдчилан сэргийлэх лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулсан.

Дүгнэлт:

Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо хангалттай бүрдсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

Зөвлөмж:

- Оюутан солилцооны хөтөлбөрийг тогтмол үйл ажиллагаа болгох
- Олон улсын чанартай оюутны дундах уралдаан, олимпиадад оюутнуудаа оролцуулах төлөвлөгөө гарган ажиллах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ-ы сайдын 2003 оны 150 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэхэд баримтлах журам” дээрх журамтай холбоотой Дээд боловсролын тухай хуулийн 2016 оны 4 сарын 14-ний өдрийн 9-р заалтад орсон нэмэлт өөрчлөлтийг үндэслэн сургалтын үйл ажиллагааг явуулдаг.
- АШУҮИС-ийн дүрмийн 4.8.1, 4.8.5 дахь заалт, Захиргааны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22 өдрийн өдрийн 21/01 тоот хурлын тэмдэглэлийн шийдвэрийг тус тус үндэслэн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах” журмын 1-р хавсралтаар баталсан оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах бүлгийн заалтыг үндэслэн оюутны шилжилт хөдөлгөөн зохицуулагддаг.

Онцлог зүйл:

- Шилжилт хөдөлгөөн хийх тухай шийдвэр суралцагч гаргахаас өмнө сэтгэлзүйн болон бусад чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ соёлыг төлөвшүүлэхэд анхаарч ажилладаг.

Дүгнэлт:

Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн зохицуулах журам маш тодорхой байдаг шаардлага хангасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Бусад сургуулиудаас шилжин ирж суралцах хүсэлт тавьж байгаа оюутнуудаас шалтгааныг тодруулан шалтгааныг 2 сургууль хамтран шийддэг тогтолцоо журам боловсруулах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн мэргэжлийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн бакалавр болон дипломын зэргийн болзол хангасан төгсөгчдөд АШУҮИС-ийн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, диплом, энгэрийн тэмдэг олгоно.
- 5.5.1.Төгсөлтийн баримт бичгийг батлагдсан дүрэм, журмын дагуу олгодог
- Бакалаврын зэргийн диплом нь АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, АШУҮИС-ийн захирал, төгсөлтийн шалгалтын ерөнхий зөвлөлийн дарга болон бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, АШУҮИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба дипломын болон бүртгэлийн дугаартай байна.
- Төгсөх оюутнуудын суралцсан хугацааны дүн тулгаж хяналтын комиссыг захирлын тушаалаар жил бүрийн 2 дугаар сард томилон ажиллаж, дүнгийн тулгалт, хяналтыг хийж баталгаажуулдаг. Бүрэлдэхүүн сургууль, ОХУГ нь төгсөлтийн баримт бичгийн оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг хянан баталгаажуулсны дараа, диплом хэвлэлтэд орохоос өмнө суралцагч өөрөө заасан хугацаанд хянан шалгана.

Онцлог зүйл:

- certify.mn блокчэйд баталгаажсан цахим дипломын санд төсөгчдийн 2000 гаран диплом бүртгэгдсэн, цааш бүртгэх ажил төлөвлөгөө гарган хийгдэж байна.

Дүгнэлт:

Төгсөлтийн баримт бичиг олгох ажил шаардлага хангасан

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- БАС-ийн төгсөгчдийн диплом ямар ямар улсад хүлээн зөвшөөрөгддөг талаарх мэдээллийг боловсруулж төгсөгчдөд өгөх
- Тэдгээр орны бакалаврын сургалтын төлбөрийн мэдээллийн сан бий болгох

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг сонгон шалгаруулах, багшийн ажлын үнэлгээ, гүйцэтгэлийг тооцохдоо АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу хэрэгжүүлдэг.
- Багш сонгон шалгаруулахдаа тэнхимийн хурлын тэмдэглэл, сургалтын албанаас гаргасан тэнхимийн хурлын тэмдэглэл, сургалтын албанаас гаргасан тэнхимийн урьдчилсан цагийн ачаалалд үндэслэн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ЗХШҮА-нд саналыг хүргүүлдэг. Саналд үндэслэн ЗХШҮА ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлаж шалгаруулалтыг сорилын шалгалт, ярилцлага гэсэн 2 үе шаттай зохион байгуулдаг. Нотлох баримтаар багшийг сонгон шалгаруулахдаа тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, хугацааг тодорхой заасан зарыг байршуулдаг. Сорилын шалгалт мэргэжил 50 хувь, англи хэл 30 хувь, ёс зүй 20 хувь байхаар тусган хэрэгжүүлдэг.
- 2022 онд 16 профессор, 25 дэд профессор ажиллаж байгаа нь нийт багш нарын 29%-г эзэлж байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт багш нарын дунд 2022 оны байдлаар ШУ-ны доктор 1, доктор 81, нийт 82 буюу 58,2% нь эрдмийн зэрэгтэй бөгөөд жил ирэх тусам энэ тоо нэмэгдэж байна. 29 нь ахлах багш, 9 нь багш, 3 нь дадлагажигч багшийн орон тоон дээр ажиллаж байна.
- Нийт багшийн орон тооны 90% нь үндсэн багш, 10%-иас доош нь гэрээт ба цагийн багш нар байдаг.
- Нэг багшид ноогдох оюутны тоо: 8-10
- Багш нарын цалингийн хэмжээ нь багшийн зэрэглэлээс хамааран жил болгон тогтвортой нэмэгдсэн байна.
- Докторантурын сургалтын төлбөрийг хөнгөлөх, судалгааны грант өгөх, 1 сарын цалинтай чөлөө өгөх гэх мэт урамшуулал байна.

Онцлог зүйл:

- Аттестатчилал хийх журам, үнэлгээний дагуу багш нар албан тушаалын зэрэглэлийг дэвшүүлэн ажилладаг. Нийт багш нарын 78%-иас дээш багш болон түүнээс дээш албан тушаалын зэрэглэлд ажиллаж байна.
- Аттестатчилал хийх журамд албан тушаалын зэрэглэлээс хамааран өөрчлөлт оруулан багш нарын үнэлж байна.
- Албан тушаалын зэрэглэлээс хамааран багш нарын гүйцэтгэх А цагийн гүйцэтгэл нь өөр өөр байдаг.
- Мэргэжлийн ахлах зэрэгтэй багш -1, тэргүүлэх зэрэгтэй багш-4, зөвлөх зэрэгтэй багш-1, спортын мастер-2, олон улсын хэмжээний мастер-2, , нийт багш нарын 67% нь 10-аас дээш жил ажилласан.
- Багш нарт зориулсан олон төрлийн цалин урамшуулалттай байна. Үүнд: оны шилдэг багш, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, ахмадын сан, эрүүл мэндийг дэмжих болзолт уралдаан тэмцээн, багш нарын бүтээлийн урамшуулал гэх мэт
- Багш нарын цалинг тодорхой шатлалтайгаар 6-10% нэмэгдүүлсэн.
- ЗГ, Төрийн одон медаль шагналд ажилчдыг нэр дэвшүүлэн хөдөлмөрийг үнэлүүлэн тодорхой хэмжээний мөнгөн урамшуулалтай байна.

Дүгнэлт:

Багш сонгон шалгаруулах, багшийн ажлын үнэлгээ, гүйцэтгэлийг тооцохдоо АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот тушаалаар батлагдсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу хэрэгжүүлдэг. 2022 оны байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нийт 141 багш нарын бүрэлдэхүүнтэй, 58%-иас дээш эрдмийн зэрэг цолтой байхаас гадны багшийн зэрэглэлтэй, үндсэн багш нь 90%-иас дээш эзэлдэг. Багш нарыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр үнэлэх журамтай. Нийт багш нарыг урамшуулан дэмжих олон талт хамтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, урамшуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- “Профессор” албан тушаалын зэрэглэлтэй багшид ноогдож буй А цагийн үндсэн ба илүү гүйцэтгэл, цагийн ачаалал нь өндөр байгаа тул бууруулах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/259 тоот тушаалаар “АШУҮИС-ийн Багшийн хөгжил батлах тухай” хөтөлбөр баталсны дагуу 2022, 2023 онуудад БАС-ийн захирлын 2023 оны А/02 тоот тушаалаар Био-анагаахын багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулсан баталсан.

- 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулсан. Үүнд:
 1. Шилдэг хүний нөөцийг бүрдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих
 2. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг хөгжүүлэх

3. Багшийн мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх
 4. Багшийн англи хэлний чадавхыг нэмэгдүүлэх
 5. Багшийн академик соёл, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх
 6. Багш нарын нийгмийн хамгааллыг дэмжихэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах
 7. Удирдлагын бүх түвшинд нэгдсэн бодлогоор багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Дотоодод сүүлийн 5 жилд:
 - Багш нарт зориулан 10 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг заах арга зүй, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан.
 - Нийт багш нар зориулсан 12 гаруй төрлийн сургалтуудад 30-67% хамрагдсан.
 - Жижиг бүлэгт зориулагдсан сургалтад 83% хамрагдсан байна.
 - Багшийг мэргэжлийн хувьд сурталчлах зорилгоор оюутнаас санал авч шилдэг 10 багшийг урамшуулсан.
 - Багш нар нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.
 - Багш нарын англи хэлний түвшнийг тогтоон нийт 12 багш түвшин ахиулах сургалтад хамрагдсан байна.
 - Багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажилладаг.
 - Сургуулиас гадна зохион байгуулагдсан 1 сар хүртэлх хугацаатай сургалтад нийт 105 багш, 1-3 сар хүртэлх хугацааны сургалтад нийт 12 багш, 3-6 сар хүртэлх хугацааны сургалтад нийт 8 багш хамрагдсан байна.
 - Нарийн мэргэжил эзэмших, мэргэжил дээшлүүлэх 3 хүртэл жилийн хугацаатай үндсэн мэргэшлийн сургалтад нийт 11 багш хамрагдсан.
 - Төрөлжсөн мэргэшлийн сургалтад нийт 13 багш хамрагдсан байна.
 - Дотоодод магистрын сургалтад 2019-2022 онуудад нийт 4 багш, дотоодод докторын сургалтад нийт 2018-2023 оны хооронд нийт 30 багш хамрагдаж суралцаж байна.

Онцлог зүйл:

- Багш нарын дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн болон шилдэг бүтээл шалгаруулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж урамшуулдаг.
- АШУҮИС-ийн багш нар нь дотоодоо докторын хөтөлбөрт хамрагдахад 30 хувийн тэтгэлэг эсвэл захирлын нэрэмжит судалгааны грант олгодог.
- Жил бүр АУБС сургалтыг зохион байгуулж 2018-2023 оны эхний хагас хүртэл БАС-н нийт 110 багш хамрагдсан байна.
- Гадаадад 2018-2023 оны хооронд 1 сар хүртэлх хугацааны сургалтад нийт 87 багш, 1-3 сар хүртэлх хугацаанд нийт 16 багш, 3-6 сар хүртэлх хугацаатай сургалтад нийт 6 багш хамрагдсан байна.
- Гадаадад магистрын сургалтад 2021 онд 1 багш, докторын сургалтад 2018-2022 онд нийт 19 багш хамрагдсан байна.
- Гадаадад докторын дараах сургалтад 4 багш хамрагдаж, 2 багш гадаадад зочин профессороор ажиллаж байна.

Дүгнэлт:

2022, 2023 онуудад БАС-ийн захирлын 2023 оны А/02 тоот тушаалаар Био-анагаахын багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулсан баталсан. Хөтөлбөрийн дагуу 2022-2024 оны хэрэгжүүлэх 7 чиглэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Багшийн хөгжлийг тогтмол тасралтгүй хөгжүүлэхээр богино ба урт хугацааны олон төрлийн сургалтад дотоодод болон гадаадад байнга тогтмол хамруулж байна. Багш нарын хөгжлийг дэмжих, мэргэшил дээшлүүлэх, ахисан түвшний сургалтад хамруулахаар сургуулийн зүгээс тодорхой хэмжээний урамшуулал олгодог нь сайшаалтай байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш нарыг хөгжүүлэхээр хэрэгжүүлж байгаа сургалтын үр дүнгийн үр өгөөжийн үнэлгээг хийх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

АШУҮИС-ийн хөгжлийн бодлогод 2015-2024 оны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.

- 2018-2022 оны эрдэм шинжилгээний тайлангаас үзвэл 1044 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, 1066 эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд шинэ бүтээл оновчтой санал, патент 18, ном товхимол, гарын авлага 257, нэг сэдэвт зохиол 68, гадаад хэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл 397-г хэвлэн нийтлүүлснээс 69 нь өгүүлэл нь Scopus-д бүртгэлтэй, олон улсын IF-тай сэтгүүлд хэвлэгдсэн байна.
- Сүүлийн 5 жилийн дотор АШУҮИС-ийн нийт багш нарын бүтээлийн 20%-ийг дангаарай БАС-ийн багш нарын бүтээл эзэлж байна.
- Их сургуулийн гарааны компаниуд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
- БШУЯ, ЭМЯ, ШУТС-н санхүүжилттай, АШУҮИС-ийн санхүүжилттай эсвэл хамтын гэрээтэй олон улсын байгууллага, их сургуулийн хүрээнд хамтран гүйцэтгэх эрдэм шинжилгээ, судалгааны нийт 47 төслийг хэрэгжүүлэн, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.
- АШУҮИС-ийн зардалд тусгаснаар эрдэм шинжилгээ судалгаанд зарцуулсан зардал 202-2021 онд нийт төсвийн 5,15% (БАС 8,624,000.00₮) , 2022-2023 онд нийт төсвийн 7,2%-г (БАС 26,800,000,00₮) эзэлж байгаа ба жил ирэх тусам нэмэгдэж байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг олон нийтэд таниулах зорилгоор олон улсын ба дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинарыг тогтмол зохион байгуулдаг (нийт 105).

Онцлог зүйл:

- Био-анагаахын хүрээлэн 2022 онд байгуулагдсанаар БШУЯ, ШУТДС-ийн санхүүжилттэй 5 төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны төслүүд хэрэгжиж байна.
- Био-Анагаах хүрээлэнг түшиглэн БАС-ийн багш, судлаач оюутнууд хамтран нийт 7 төслийг хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрөөр суралцагчид дипломын ажил гүйцэтгэх лабораторийн орчин нөхцөл, эрдэм шинжилгээний төсөлд ажилд хамрагдан судлаачийн ур чадвараа сайжруулах бүрэн боломжтой байна. Бакалаврын дипломын ажил удирдсан багш нарт А цагийн гүйцэтгэл дээр 40 оноог нэмж тооцдог байна.
- 2018-2022 онд БАС-ийн багш нар үндэсний болон олон улсын нэр хүнд бүхий хэвлэлд нийт 1090 бүтээл хэвлүүлсний 647 нь дотоодын сэтгүүлд, 443 нь олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн. Журмын дагуу Scopus, Web of Sciences-д бүртгэлтэй IF бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн БАС-ийн 15 багш нарт бүтээлийн мөнгөн урамшуулал (2022 онд 11 сая) жил бүр тогтмол олгож байна.
- БАС-ийн нийт багш судлаачдын 2018-2022 онд олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлээс 2022 онд нийт 705 эшлэл авагдсан байна.
- БАС-ийн эрдэмтэн профессор багш судлаачдын сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл 415 байна.
- БАС-ийн багш тус бүрд оногдох олон улсын болон дотоодын сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийн тоо жил бүр нэмэгдэж 2012-2022 оны хооронд тогтвортой өссөн байна.

Дүгнэлт:

Био-анагаахын хүрээлэн байгуулагдсан нь БАС-ийн багш, эрдэмтэн судлаач, оюутан нар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэн дотоодын ба олон улсын мэргэжлийн сэтгүүлд судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлж, олон нийтэд таниулан сурталчилж байна. Эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх нь нийт багш, судлаач, оюутан нарыг мэргэжлийн түвшинд улам хөгжин дээшлүүлэх бололцоог олгохоос гадна төгссөн гарч буй төгсөгч нь ажлын байрандаа судлаач болон лабораторийн ур чадвар, мэдлэг, хандлагыг төлөвшүүлсэн мэргэжилтэн болоход эерэг нөлөө үзүүлсэн. АШУҮИС-иас эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр багш судлаач нарт бүтээлийн мөнгөн урамшуулал олгож байгаа сайн талтай. “Био-анагаах ухаан судлаач” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нийт багш нар нь сургалтын, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр тасралтгүй тогтмол хөгжиж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш нарын судалгаа шинжилгээний ажлын үр дүн, эрдэм шинжилгээний бүтээлийн ололт амжилт, шинэ мэдлэгээр хичээлийн хөтөлбөрийн сайжруулалт, даалгаврын сангийн баяжуулалтад тогтмол тусгах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа, хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, сурган заах арга зүй, эрдэм шинжилгээ судалгаа ажилд оролцуулсан үнэлгээ, багш нарын аттестатчлалын үнэлгээ зэргийг хийсэн байна.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох” А/103 тоот журмын 3.8-д заасны дагуу профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш албан тушаалын зэрэглэлийн дагуу сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ, оюутны үнэлгээ гэсэн 5 чиглэлээр 100 оноонд дүйцүүлэн үнэлж, 85-аас дээш бол сайн, 70-85% оноо бол дундаж түвшинд байгаа багш, 60-70% бол зарим шалгуурыг хангасан, заримыг нь дахин гүйцэтгэх, 0-60% бол хангалтгүй гэж үнэлдэг.
- Дадлагажигч багш 1 ба 3 жилд, багш 3 жил тутамд, ахлах багш, дэд профессор багш 4 жил тутамд, профессор 5 жил тутамд өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтаар баталгаажуулан АШУҮИС-ийн Багшийн хөгжил цахим сургалтын газрын ажлын хэсгээр хөндлөнгийн үнэлгээг батлагдсан шалгуур хуудсаар хийдэг. Хөндлөнгийн үнэлгээний дүн нь багшийн албан тушаалын зэрэглэл дэвших, буурах үндэслэл болдог.
- 2018-2022 онд аттестатчилалд орсон багш нарын дүнг нэгтгэн дүгнэхэд 2018-2020 онуудад нийт багш нар бүгд хангалттай, 2021 онд 93% нь хангалттай үнэлэгдсэн.

Онцлог зүйл:

- 2022 оны хичээлийн жилээс аттестатчиллын шалгуурыг багшийн албан тушаалын зэрэглэлээс хамааруулан шинэчилсэн байна.
- 2023-2024 оны хичээлийн жилээс албан тушаалын зэрэглэлд тохируулан босго оноог өөрчилсөн.
- Багшийн аттестатчиллыг жилд 2 удаа зохион байгуулдаг.

Дүгнэлт:

АШУҮИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох” А/103 тоот журмын дагуу өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хийдэг. Үнэлгээний журмын дагуу багш нарын сургалтын ачааллын 30 хүртэл хувийг төгсөлтийн сургалтаар биелүүлэх боломж бүрдэж, шүүмж бичих, дипломын оюутан удирдах, зөвлөх гэх мэт ажлуудыг оноогоор үнэлэн тусгасан, эрдэм шинжилгээний ажилд ноогдох оноог нэмэгдүүлэн багшийн ажлын үнэлгээнд оруулсан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутнаас авч буй хөндлөнгийн үнэлгээг имэйл хаягаар биш, нууцлалын зэрэглэлтэй байдлаар авах
- Гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын тогтолцоог бий болгох

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын албатай. Үүнд:
 1. Анхы бүтэц 2007 онд ЭМШУИС-ийн хяналт шинжилгээ үнэлгээний баг,
 2. 2010 онд “Хяналт шинжилгээ, үнэлгээний алба”,
 3. 2013 онд “Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба”,
 4. 2016 оны А/15 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй “Чанарын баталгаажилтын алба”,
 5. 2021 онд “Хяналт шинжилгээ, үнэлгээний газар” болон өргөжин, үйл ажиллагаа, үүрэг чиглэлийн цар хүрээгээ тэлсэн байна.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын сайжруулалтыг 2015 оноос хойш тогтмол хийж, холбогдох ажлын төлөвлөлтийг хийж ажиллаж байна. Үүнд:
 1. АШУҮИС-ийн захирлын 2015 оны А/113 тоот тушаалаар Хөтөлбөрийн хороо байгуулагдсан;
 2. 2016 оны А/56 тоот тушаалаар АШУҮИС-ийн хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам батлагдсан;
 3. 2022 оны А/225 тоот тушаалаар хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах шинэчлэгдсэн журам батлагдсан;
 4. 2023 оны А/22 тоот тушаалаар Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.
 5. АШУҮИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагааг зохицуулах журам.
 6. АШУҮИС-ийн Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам.
 7. АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйд хийсэн шинэчлэл, өөрчлөлтийг он тус бүрээр харьцуулан гаргаж, дүгнэлт хийж байх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн сонирхогч талын эрэлт, хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох (гадаад, дотоод)

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Био-анагаах судлаач мэргэжилтэн”-ээр суралцаж буй оюутны сэтгэл ханамжийн судалгааг жил бүр тогтмол авдаг. Судалгааны дүнгээс харахад өссөн байна.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Судалгааны дүн 78.2%-93.8% болтол өссөн байна.
- Нийт төгсөгчдөөс анагаах ухааны 79 магистр, 17 доктор төрсөн байгаа нь энэ мэргэжил шинжлэх ухааны салбарт хөрвөн ажиллах боломж, үнэ цэнийг үзүүлж буй юм.

Анхаарах асуудал:

- Нийт төгсөгчдийн хэдэн хувь нь магистр, доктор зэрэгтэй, мөн мэргэжлийн зэрэг гэх мэт үзүүлэлтийг гаргасан нэгтгэл хийх
- Дотоод чанарын баталгаажилтын албаны ажлыг сайжруулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулж, харьцуулалт хийж, хөтөлбөрийн сайжруулалтад тусгах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөр нь 2 удаа магадлан итгэмжлэгдсэн байна.
- Өмнөх магадлангийн шинжээчдээс өгсөн 8 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.
- Төгсөгчдийн 52.5% нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагад, 5% нь судалгааны байгууллагад, 8% нь гадаадын их дээд сургуульд сурч, 34.5% нь бусад чиглэлээр ажиллаж байна.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг.
- Био-Анагаах судлаач мэргэжлээр төгсөгчдийн 25% нь гадаадад мэргэжил дэшлүүлсэн байна.

Онцлог зүйл:

- Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөртэй

Анхаарах асуудал:

- Магадлангаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрхэн ажилласан, зөвлөмжийг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Нийгмийн хариуцлагын хүрээнд дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэн, өөрийн оронд био-анагаахын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг түүчээлэн ажиллаж байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангааг үй	Үндэслэл,
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн хөтөлбөр	3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл	5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			Бүрэн хангасан
Дүгнэлт		Био-анагаахын сургуулийн Био-анагаах ухаан бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан тул магадлан итгэмжлэх саналтай байна.			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	АШУҮИС-ийн Био-Анагаахын сургууль
Хөтөлбөрийн нэр	Био-Анагаах Ухаан
Хөтөлбөрийн индекс	D091401
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> – Хэрэгцээ шаардлагыг тоон мэдээлэлд үндэслэн гаргах, цаашдын прогнозыг гаргах – Мэргэжлийн онцлогоос шалтгаалан оролцогч талуудын оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх. – Цаашид хөтөлбөрийн орц, гарц, явцыг үнэлж, сайжруулалт хийж хэвших – Сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт аргыг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх – Хөтөлбөрт гарч болох үл тохирлуудыг гаргадаг байх, цаашид засаж залруулах ажлын төлөвлөгөө гаргах, сайжруулалт, ахиц дэвшлийг гаргадаг байх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> – Хичээлийн хөтөлбөрийг илүү боловсронгуй болгож, үнэлгээний арга хэлбэрийг суралцахуйн үр дүн бүрээр блумын таксономийн 6 түвшинтэй уяалдуулан боловсруулах – Эмнэл зүйн хичээлийн хувьд лабораторийн шинжилгээнд үнэлэлт, дүгнэлт, тайлбарлал өгөх чадварыг илүү эзэмшүүлэх – Олон улсын хөтөлбөр, дадлага солилцоог идэвхжүүлэх – “Био-анагаах ухаан судлаач” хөтөлбөрийн үр дүн болох мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох даалгаврын санг Блүүмийн таксаномын 6 түвшингээр тодорхойлох, дамжаа бүрд даалгаврын сангийн үнэлгээний бюпринтийг тодорхойлох
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> – Төв болон төрөлжсөн лабораториудад ашиглаж байгаа өндөр үнэтэй багаж төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулахад шаардлагатай засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлийн зардлыг улирал бүрээр гарган ханган ажиллах нэгдсэн төлөвлөгөө гаргах – Тодорхой урсгал зардлаа төлөн судлаачид, судалгааны багууд БАХ-д ажилуулах боломж эрх зүйн орчинг улам сайжруулах төлөвлөгөө гарган ажиллах

	<ul style="list-style-type: none"> – Дараагийн 2024-2029 оны 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гаргах – Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжтэй байдалд үнэлгээ хийх, суралцагчийн тоотой харьцуулж, хүртээмжтэй болон чанартай эсэхэд анхаарах. – Сургалтын бааз болон сургуулийн эмнэлэг дээр багш, оюутнуудын хэвийн ажиллах нөхцөл бүрдүүлэх, өртөг үр дүнгийн шинжилгээг тогтмол давтамжтай хийж, байнгын сайжруулалт хийх ажилд хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх.
<p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> – Хөгжлийн стратеги төлөвлөгөөг гаргаж, хүрэх үр дүн тооцдог байх – Холбогдох эрх бүхий байгууллагуудад тус хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжилтний хөгжлийн загварыг шинэчлэн боловсруулж, албан тушаалын тодорхойлолтод хамруулж, хууль эрх зүйн чадамжтай болгох талаар санал хүргүүлж, төгсөгчдийн эрх ашгийн төлөө хамтран ажиллах – Хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтад зарцуулах зардлыг нэмэгдүүлэх – Оюутны шилжилт хөдөлгөөний шалтгаан дээр анхаарч ажиллах – Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц хөтөлбөр, төлөвлөгөө гарган, хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах – Био-анагаах судлаач мэргэжилтний үнэ цэн, мэргэжлийн онцлогийг оюутан, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчдод ойлгуулах, сурталчлах ажлыг түгээн дэлгэрүүлэх
<p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> – Элсэлтийн тоог зах зээлийн хэрэгцээ шаардлыг зохих байгууллагуудтай хамтран тодорхой давтамжтай судлан, тогтоодог болох. - Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын ач холбогдлыг сурталчилж, суралцах хүсэлтэй оюутны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллах – Одоо мөрдөгдөж байгаа БАС-ын ажлын байрны талаарх тушаал, шийдвэр, дүрэм стандартуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж төгсөгчид бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэх – Эрүүл мэндийн байгууллагын удирдлага болон хүний нөөцийн мэргэжилтэнд зориулсан 4 цагийн Био-анагаах судлаач мэргэжлээр төгсөгчдийн чадвар, хийж чадах ажлуудын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, тэдэнд тодорхой давтамжтай сургалт явуулах төлөвлөгөө гарган ажиллах – Оюутан солилцооны хөтөлбөрийг тогтмол үйл ажиллагаа болгох – Олон улсын чанартай оюутны дундах уралдаан, олимпиадад

	оюутнуудаа оролцуулах төлөвлөгөө гарган ажиллах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> – “Профессор” албан тушаалын зэрэглэлтэй багшид ноогдож буй А цагийн үндсэн ба илүү гүйцэтгэл, цагийн ачаалал нь өндөр байгаа тул бууруулах чиглэлээр ажиллах – Багш нарыг хөгжүүлэхээр хэрэгжүүлж байгаа сургалтын үр дүнгийн үр өгөөжийн үнэлгээг хийх – Багш нарын судалгаа шинжилгээний ажлын үр дүн, эрдэм шинжилгээний бүтээлийн ололт амжилт, шинэ мэдлэгээр хичээлийн хөтөлбөрийн сайжруулалт, даалгаврын сангийн баяжуулалтад тогтмол тусгах – Оюутнаас авч буй хөндлөнгийн үнэлгээг имэйл хаягаар биш, нууцлалын зэрэглэлтэй байдлаар авах – Гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын тогтолцоог бий болгох
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> – Хөтөлбөрийн сонирхогч талын эрэлт, хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох (гадаад, дотоод) – Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулж, харьцуулалт хийж, хөтөлбөрийн сайжруулалтад тусгах

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн “Био-Анагаах ухаан” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжил”-ийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /Л.Уламбаяр/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Н.Наранбат/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Г.Түвшинжаргал/

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



АШУУИС

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

**БИО-АНАГААХЫН
СУРГУУЛЬ**

С.Зоригийн гудамж, Сүхбаатар дүүрэг,

Улаанбаатар хот, ш/х-48/111, 14210

Утас/Факс: 11-31 90 65

Цахим шуудан: biomedicine@mnu.edu.mn

2023.12.22 № 206

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН

ИТГЭМЖЛЭЛИЙН

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

АШУУИС-ийн БАС-ийн Био-Анагаах ухаан хөтөлбөрт ажилласан шинжээчдийн тайлантай танилцаж хөтөлбөрийн багаас дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний Шалгуур II, IV, VI, VII – д өгсөн шинжээчдийн саналтай хөтөлбөрийн баг санал нэг байна. Дараах шалгуурын хувьд:
2. Шалгуур I хувьд 1.1-д өгсөн шинжээчдийн санал болох *Хөтөлбөрийн агуулгын харьцуулалт хийсэн боловч кредит цаг нилээд зөрүүтэй байгаа нь бэлтгэн гаргаж буй мэргэжилтэн олон улсын түвшинд дүйцэхүйц гэдэгтэй нийцэх эсэх гэсэн санал зөвлөмж нь Бид сургалтын агуулгын хувьд олон улсын түвшинд дүйцүүлж заавал судлах болон заавал судлах сонгон хичээлийн хувьд агуулга ижил болсон тухай тайланд тусгасан болно.*
3. Шалгуур 1.2-д өгсөн шинжээчдийн санал болох *Мэргэжилтний загварт ажлын байрны тодорхойлолтыг товч, ойлгомжтой дүрсэлж тайлангийн нотлох баримт 3 буюу төгсөгчийн загвар хэсэгт багтаасан болно.*
4. Шалгуур 1.3-д өгсөн шинжээчдийн санал болох *Хичээл бүрийн хөтөлбөрийн төгсгөлд үнэлгээний олон талт аргуудыг ашигладаг болохыг тусгаж нотлох баримт 18, хөтөлбөрийн сайжруулалт, ахиц дэвшлийг тогтмол хийдэг болохыг тайлангийн нотлох баримт 17-д тус тус тусгасан болно.*
5. Шалгуур 3.3 хувьд хавсралтаар тайлбар хүргүүлж байна.
6. Шалгуур V-ийн хувьд Шалгуур 5.1-д өгсөн шинжээчдийн санал болох *"Шаардлагатай байгаа дунд мэргэжилтний судалгаа гарган элсэлтийн тоог нэмэгдүүлэх (лабораторийн технологч гм,). Зах зээлд шаардлагатай байгаа мэргэжлүүдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан элсэлт авах (флиботомист - Phlebotomist гм)"* гэсэн зөвлөмж нь Био-Анагаах ухаан бакалаврын хөтөлбөртэй шууд хамааралтай бус *Лабораторийн техникч мэргэжлийг Анагаах ухааны сургууль тусдаа хөтөлбөрөөр бэлтгдэг.*

ЗАХИРАЛ

Г. ДАРАМБАЗАР

**АШУҮИС-ийн Био-Анагаах ухаан хөтөлбөрт магадлан шинжилгээ хийсэн
“Шинжээчдийн тайлан”-гийн зарим зөвлөмжид өгөх тайлбар
(III шалгуур)**

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр		
1	Номын фонд хадгалах зай тайлбайг шат дараатай бий болгох, хадгалалт галын аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> АШУҮИС-ийн Анагаах ухааны төв номын сангийн барилга нь 2015 оны 11 сарын 05-д ашиглалтад орсон. АШУҮИС-ийн зүүн кампус (МЯЭ, АУС, МАУОУС)-т шинэ номын сан баригдаж байгаа бөгөөд 2024 оны I улиралд ашиглалтад орно. Галын аюулгүй байдлыг хангасан гэж үзэж байна. Нотолгоог зургаар явуулав.
2	Магистр, докторуудын бүтээлийг цахим хэлбэрээр хадгалах, үзэх боломжийг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэцийн хэрэгцээг гарган үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах	Магистр, докторуудын бүтээлийг цахим хэлбэрээр хадгалан, үзэх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Учир нь шинжээч нарыг АШУҮИС-д ажиллах үед Анагаах ухааны төв номын сангийн программаас профессор А.Гүрбадамын багшийн нэрээр хайлт хийж, магистр, докторуудын бүтээлийг гарган, уншигдах боломжтой эсэхийг шалгуулсан билээ.



IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог Нэр	Албан тушаал	Албан байгууллага	Утасны дугаар	Цахим хаяг
1	Г.Оч	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний лавлагаа лабораторийн албаны дарга	НЭМҮТ	88021964	Och.ncph@gmail.com
2	Г.Энхчимэг	Нэгдсэн лабораторийн эрхлэгч	ТТАХНЭ	88321881	Chimgee870321@gmail.com
3	Т.Мөнгөнтуул	Нэгдсэн лабораторийн эрхлэгч	ЭХЭМҮТ	99099017	Munguntul.t@ncmch.gov.mn
4	Х.Өнөржаргал	Нэгдсэн лабораторийн эрхлэгч	Төмөр замын нэгдсэн эмнэлэг	99883612	Unurjargal.ubtz@gmail.com
5	Н.Эрдэнэбаяр	Ерөнхий захирал	ЦССҮТ	88118058	nmjlerdenebayar@gmail.com
6	Д.Орлом	Лабораторийн эрхлэгч	Эх нярайн эрүүл мэндийн төв	99457337	Orlom.deleg0511@gmail.com
7	Б.Бумдэлгэр	Нэгдсэн лабораторийн албаны дарга	ХӨСҮТ	80456624	
8	Энхцэцэг	Лабораторийн эрхлэгч	Цэргийн төв эмнэлэг	99871857	
9	Шинэсүх	Лабораторийн эрхлэгч	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	99031671	gshinesukh@gmail.com
10	Б.Батчимэг	Лабораторийн эрхлэгч	Баянзүрх нэгдсэн эмнэлэг	88864055	Baagiibatchimeg757@gmail.com
11	Ш.Тунгалаг	Ерөнхий захирал	Экспресс оношлогооны төв	88111409	Express_lab@yahoo.com
12	Отгонцэцэг	Лабораторийн эрхлэгч	Итгэл эрүүл мэндийн төв	99278181	Otgoo.itgel67@gmail.com
13	Баасанхүү	Захирал	Бона вита эмнэлзүйн төв лаборатори	88754455	baasankhuu@bonavits-laboratory.com
14	Б.Бадмаараг	Лабораторийн эрхлэгч	Прецилаб эрүүл мэндийн лаборатори	88845282	Precilabllc@gmail.com
15	С.Мөнхбаяр	Эрдэм шинжилгээний лабораторийн эрхлэгч	Анагаах ухааны үндэсний хүрээлэн	88028860	Munkhbayar.ims@mnu.ms.edu.mn
16	Б.Лхагвасүрэн	Лабораторийн эрхлэгч	Өөжинмед үр шилжүүлэн суулгах төв	89880078	lkhagvasuren@ojinmed.mn

Төгсөгчдийн төлөөлөл

	Овог	Нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар	И-мэйл хаяг
1	Цогтжаргал	Уранцэцэг	2005	Чанарын менежер	ХӨСҮТ	99039428	urantsetsegt@gmail.com
2	Цэдэнбал	Наранзул	2006	Вируслогийн лабораторийн эрхлэгч	ХӨСҮТ	96822555	naranzulnicmng@gmail.com
3	Түвшинтөр	Буянхүү	2007	Биохимийн тэнхим	АШУҮИС	99826664	buyankhuu@mnums.edu.mn
4	Оқдоо	Сүрэн	2008	Багш	АШУҮИС	99065165	suren@mnums.edu.mn
5	Догсом	Оюунгэрэл	2010	Солонгос	Солонгос	фейсбүүк	oyungerel.d@mnums.edu.m
6	Батчулуун	Хонгорзул	2010	БАХ	БАХ	99068715	
7	Батбаатар	Батчимэг	2011	Эрдэм шинжилгээний ажилтан	Анагаах ухааны хүрээлэн,	99199239	batchimeg.ims@mnums.edu.mn
8	Баярсайхан	Туул	2012	АУЗЛ-н цитокенетикийн эмч	ЭХЭМҮТ	88054030	tuul.bayar@gmail.com
9	Баатар	Буяндэлгэр	2012	Генетикийн лабораторийн эрхлэгч	Бонавита	86369979	bbbuyna@gmail.com
10	Хурамхаан	Цэнд-Аюуш	2012	Микробиологч	Грандмед эмнэлэг,	89014004	tsend-auysh@gtc.mnums.edu.mn
11	Галбадрах	Нандин-Эрдэнэ	2014	Захирал	Тод онош	99364463	nandiushka0627@gmail.com
12	Хүдэр	Авирмэд	2014	Молекул биологич	СХД лаборатори	88600798	aviraa.huder@gmail.com
13	Энхтуяа	Агиймаа	2015	БАМ	SOS мэдика монголиа эмнэлэг,	89094546	dashkagima0103@gmail.com
14	Ямранз	Нарангэрэл	2015	Цус сэлбэлтийн эмч	ГССҮТ	99914193	yamranznarangerel@gmail.com
15	Доржсүрэн	Золбоо	2016	Эмбриологич	RMC үр шилжүүлэн суулгах төв,	95391218	zzobo0845@gmail.com
16	Балжинням	Лхагвасүрэн	2016	Лабораторийн мэргэжилтэн	Өөжинмед,	89880078	Lkhagvasuren@ojinmed.mn
17	Даваа	Наранбаатар	2017	БАМ	Онош мед,	93333773	avaanaranbaatar@gmail.com
18	Хас-Очир	Доржсүрэн	2017	Лабораторийн эмч	Төмөр замын төв эмнэлэг,	88072246	hasochir.dorjsuren@gmail.com
19	Зулмөнх	Гэрэлцэцэг	2019	Био-анагаахын мэргэжилтэн	Монгол Японы эмнэлэг	80044240	gereltsetseg@mnums.edu.mn
20	Чадраабал	Жадамба	2019	Биологийн тэнхимийн хичээлийн туслах ажилтан	АШУҮИС Био-анагаахын сургууль	96692489	jadamba@mnums.edu.mn
21	Нямсүрэн	Уянгахорол	2020	Лабораторийн эмч	АШУҮИС-ийн төв эмнэлэг	99360786	uyangakhorol@mnums.edu.mn
22	Д	Мөнхжаргал	2020			99303080	muugii.munkhjargal04@gmail.com

23	Батмөнх	Золбоо	2021	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн борлуулалтын менежер	“Баянгол Мед” ХХК	86810819	zolboozoya@gmail.com
24	Ууганбаяр	Төмөр-Очир	2021	Эм, Урвалж оношлуурын борлуулалтын албаны ахлах менежер	“Баянгол Мед” ХХК	99967918	Supply2@bayangolmed.mn
25	Жамсран	Тэмүүлэн	2022		Томуужин альтернатив сургууль	95194000	temka.jomko@gmail.com
26	Батхуяг	Биндэрьяа	2022	Био-анагаахын мэргэжилтэн	Энхжин Б лаборатори	89950710	pmm17d080@st.mnums.edu.mn
27	Амар	Намуун	2022	Эмнэлзүйн лаборатори ахлах лаборант	Дархан нэгдсэн эмнэлэг Эмнэлзүйн лаборатори	90147727	namuun.amar96@gmail.com
